МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмар гараг

	Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
	Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 5
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6 – 42
1.	***Байнгын хорооны тогтоолын төсөл*** */Засгийн газарт чиглэл өгөх тухай/*	7 – 10
2.	***Байнгын хорооны тогтоолын төсөл*** */Засгийн газарт чиглэл өгөх тухай/*	10 – 11
3.	***Байнгын хорооны тогтоолын төсөл*** */Ажлын хэсэг байгуулах тухай/*	11 – 14
4.	***Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Үндэсний дата төв болон И-Монгол академийн захирлын мэдээлэл***	14 – 42

Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 17 цаг 52 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Мөнхбат, Т.Мөнхсайхан, Б.Пунсалмаа, Ч.Ундрам, С.Цэнгүүн.

Нэг.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл */Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонссонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар үг хэлэв.

Ж.Золжаргал: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 1
Бүгд: 6
83.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцож, 100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл */Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг сонссонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Золжаргал: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 1
Бүгд: 6
83.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл */Хилийн чанад дахь Монгол иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол цахим систем ашиглан сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Ж.Золжаргал “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Золжаргал: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 1
Бүгд: 6
83.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 18 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Үндэсний дата төв болон И-Монгол академийн захирлын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, мөн газрын ахлах референт Л.Мягмарсүрэн, референт П.Алтанчимэг, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, мөн үйлдвэрийн газрын Цахим засаглалын хэлтсийн дарга Х.Энхманлай, “Үндэсний Дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, мөн үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн газрын дарга Э.Баттөр, “Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл” ТББ-ын хүндэт тэргүүн Н.Номун-Эрдэнэ, мөн зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Мөнхдэлгэр, зөвлөх Б.Өлзийбат, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын орон тооны бус зөвлөх Б.Батжаргал, Ж.Жамсрандорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт Р.Дэлгэрмаа нар байлцав.

Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, “Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл” ТББ-ын хүндэт тэргүүн Н.Номун-Эрдэнэ нар тус тус танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Галбадрах, Д.Бум-Очир, М.Ганхүлэг, Ж.Золжаргал нарын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, “Үндэсний Дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаарх Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, “Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл” ТББ-ын хүндэт тэргүүн Н.Номун-Эрдэнэ нарын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 19 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр 19 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Ж.ЗОЛЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
17 цаг 52 минут

ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Золжаргал: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Хуралдааны ирц 54.5 хувиар бүрдсэн тул Байнгын хорооны хурлыг эхлүүлэх гэж байна.

Тэгээд ирцийг танилцуулъя. Чинбатын Анар гишүүн ирсэн, Энхбаярын Батшугар гишүүн ирсэн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн ирсэн, Жанчивын Галбадрах гишүүн ирсэн, Жаргалсайханы Золжаргал байна, Чинбатын Номин гишүүн ирсэн байна.

Ингээд 54.5 хувиар ирц бүрдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт нь, Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Үндэсний дата төв болон И-Монгол академийн захирлын мэдээллийг тус тус сонсох.

Хоёрдугаарт нь, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”. Хуулийн хэрэгжилтийг хангах талаар Байнгын хорооны тогтоолын төсөл.

Гуравдугаарт нь, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахим орчинд байршуулах талаар.

Дөрөвдүгээрт нь, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Хилийн чанад дахь монгол иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол цахим систем ашиглах боломжийг нэмэгдүүлэх, сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг гээд ийм дараалалтай байгаа.

Тэгээд хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу?

Надад санал байна. Хэлэлцэх асуудлын хувьд эхлээд тогтоолын төслөө ярьж хэлэлцэж батлаад, тэгээд дараа нь дэлгэрэнгүй танилцуулга руугаа орох байдлаар. Ийм саналтай байна. Энэ саналын томьёоллын дэмжье гэсэн байдлаар санал хураалт.

Хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулах санал дэмжигдлээ. 83.3 хувиар.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Нэг.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Хуулийн хэрэгжилт хангах талаар.

Энэ болохоор бид энэ Байнгын хорооны хурлаар болон Байнгын хорооны гишүүдтэй төрийн байгууллагуудаар явж ажилласан.

Байнгын хороон дээр төрийн байгууллагуудаас мэдээлэл сонссон.

Тэгээд энэ бүх ажлын үр дүнд гараад, зарим ажил нь хэрэгжээд эхэлчихсэн явж байгаа. Одоо үүнийгээ албажуулж тогтоол гаргах ийм төсөл байна.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны гишүүд Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв болон Зэвсэгт хүчний төв, үндэсний төвүүд дээр ажилласан.

Дээрээс нь улсын төсвийг Улсын Их Хурлаар хэлэлцэх үеэр мэдээллийн технологийн чиглэлээр зарцуулж байгаа төсвийн зарцуулалтыг гаргах. Энэ тал дээр бас бид нэлээн ажилласан.

Тэгээд ингээд үзэхэд кибер аюулгүй байдалд зарцуулж байгаа төсвийн хэмжээ, мэдээллийн технологийн чиглэлээр гаргаж байгаа зардлын хэмжээг тусад нь ангилсан зүйл байдаггүй. Тэгээд энэ үндэслэлээр Кибер аюулгүй байдлын зөвлөлд хандаад, асуулт явуулаад зөвлөл дээрээс гарсан дүгнэлт нь Засгийн газар луу очоод ингээд киберын чиглэлээр эдийн засгийн ангилал гаргах ийм чиглэл гарсан байгаа юм.

Мэдээллийн технологийн тоног төхөөрөмж нь машин механизм, эмнэлгийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэлтэй хамтаар нэг багц дүнд орж явдаг.

Тэгээд эдгээрээс болоод энэ салбарын яг төсвийн зарцуулалт нь хэд байна вэ, үр ашигтай байна уу гэдгийг хянах, тэгээд үр ашгийг сайжруулахад хүндрэл учрах нь. Ийм учраас мэдээллийн технологийг мөн ялгаагүй тусад нь ангилдаг болох шаардлага байна гэж бид энэ төрийн байгууллагуудад ажилласан болон Байнгын хороон дээр хийсэн сонсголын үр дүнгээр тийм дүгнэлт, ойлголтод бол хүрсэн.

Тэгээд энэ ажлуудын үр дүнд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Байнгын хорооноос явуулсан албан бичгийн хүрээнд одоо тус яаманд бүртгэлтэй 313 цахим систем байгаагаас хуулийн дагуу зөвлөмж, дүгнэлт гаргуулсан нь 28 байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл 10 хувь нь хүрэхгүй хуулийн дагуу зөвлөмж, дүгнэлт аваагүй байна гэсэн үг.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлд энэ мэдээлэл хариуцагч нь нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө цахим хөгжил харилцаа холбоо эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулах ёстой.

Тэгэхээр энэ маань бол ингээд хангалттай хэрэгжээгүй байгаа.

Мөн өнгөрсөн 2014 оноос 2024 оны хооронд Монгол Улсын хэмжээнд нийтдээ 351 арга хэмжээ, мэдээллийн технологи, цахим системд 2.2 их наяд төгрөг зарцуулсан.

Ингээд эндээс тэр 351-ээс шаардлагатай, яаралтай нь 172, тэгээд шаардлагатай нь 69, ирээдүйд хэрэгжүүлэх шаардлагатай 34, шаардлагагүй 76 гэх мэт ингэж ангилж хийсэн нэг судалгааны материал түрүүчийн Засгийн үед гарсан байдаг.

Тэгээд үүнийг шинэчлэх ажлыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаман дээр хийгээд хаврын чуулганаар танилцуулах ёстой. Ийм ажил явагдаж байгаа.

Тэгэхээр энэ бүхнийг дүгнээд гаргаж байгаа энэ тогтоолын төслийг Та бүхэндээ уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол.

Засгийн газарт чиглэл өгөх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар сонссон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг хэлэлцээд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д даалгасугай.

1/Улсын нэгдсэн төсвийн ангилалд Мэдээллийн технологийн арга хэмжээ, кибер аюулгүй байдлын ангиллын зардлыг шинээр нэмж, тус бүрд программ хангамж, техник хангамжаар ялган бүртгэх нөхцөл бүрдүүлэх;

2/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулж, цахим хөгжил, инновац, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвлөмж, дүгнэлт гарсны дараа холбогдох төсөл, хөтөлбөрт зориулсан санхүүжилт олгох.

2.Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт асуух, үг хэлэх гишүүн байхгүй байна. Санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. Байна гэнэ. Ч.Анар гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Ч.Анар: Энэ хоёр тогтоолын төсөл орж ирж байгаа юм байна.

Энэ хоёр тогтоолын төсөл нь төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэлийн ажлын хэсэгтэй уялдаж ажиллах зайлшгүй шаардлагатай байгаа.

Тэрийг цаашид байгуулж байгаа ажлын хэсэг болон тогтоолын чиг үүрэгтэйгээ уялдуулахыг Байнгын хорооны дарга болон Байнгын хорооны гишүүдэд хүсье.

Ж.Золжаргал: Хүсэлтийг хүлээж авлаа. Протоколд тэмдэглээд. Цаашид уялдаатай ажиллах тал дээр анхаарна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. /алх цохив/

Санал хураалтыг цуцалъя. Хүчингүй болгоё.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

Э.Батшугар гишүүн протоколд дэмжсэнээр.

Ингээд 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хоёр.“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл. Төсвийн ангилал зардлын нэгдсэн мэдээллийн талаар.

Тогтоолын төслөө уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

Засгийн газарт чиглэл өгөх тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар сонссон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Сангийн сайдын мэдээллийг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1/Улсын төсвийн сар, улирал, жилийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээллийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсвийн орлого, хөрөнгийн зардал, урсгал зардал, тусгай сангууд, концессоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, гадаадын зээл, тусламж зэрэг загварын дагуу нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар цахим орчинд байршуулж, зардлын задаргааг одоогоор хөгжүүлээд байгаа цахим талбаруудтай холбон харах боломжийг бүрдүүлэх;

2/Төсвийн тухай хуулийн $28^{1}2.4$, $29^{1}.3$ заалтуудын хэрэгжилтийг хангуулан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаал “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангах, цахим орчинд байршуулж буй төсвийн талаарх мэдээллийг эдгээр

журмуудын хавсралтад тусгасан загварт хууль тогтоомжийн хүрээнд нийцүүлэх, мэдээллийг тогтоосон хугацаанд нь нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар оруулах;

2.Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2025 оны хаврын эээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүн байвал нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой санал гаргах гишүүн байна уу? Санал гаргах гишүүн байхгүй байна.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

83.3 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж баталлаа.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Ажлын хэсэг байгуулах тухай/

Гуравдугаар хэлэлцэх асуудал руугаа оръё. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хилийн чанад дахь Монгол иргэд төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол системийг ашиглан сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлан санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг. Энэ ажлын хэсэгтэй холбоотой мэдээллийг Байнгын хорооны гишүүдэд тараасан байгаа.

Тогтоолын төсөл уншиж өгөөд, тэгээд гишүүдээс байр суурь асууя. Тогтоолын төслийн дараа хугацааны төлөвлөлтөөрөө дэлгэрэнгүй танилцуулгыг бид нар авна.

Тэгэхээр дэлгэрэнгүй танилцуулга, хэлэлцүүлгийг тогтоолын төслийн араас явуулахаар төлөвлөсөн байгаа.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол.

Ажлын хэсэг байгуул болгох тухай.

Монгол Улсын Их Хурлын хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар сонссон Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаар Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний дата төв болон И-Монгол академиас ирүүлсэн мэдээлэлтэй танилцаж хэлэлцээд Хилийн чанад дахь Монгол иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол цахим систем ашиглан сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлан санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Бум-Очир -Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ж.Золжаргал -Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн

Ж.Галбадрах -Улсын Их Хурлын гишүүн
Б.Пунсалмаа -Улсын Их Хурлын гишүүн
С.Цэнгүүн -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын албанаас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Д.Бум-Очир/-т зөвшөөрсүгэй.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ж.Золжаргал гэсэн ийм томьёололтой “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой санал хэлэх гишүүн байна уу? Нэрс дээр санал өгөх хүн байна уу? Байхгүй. Тогтоолын төсөлтэй холбоотой санал өгөх гишүүд байхгүй байна.

Д.Бум-Очир гишүүний хүсэлтийг уншаад өгчихье. Тэгээд санал хураая.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очироос ирүүлсэн албан бичгийг Та бүхэндээ уншиж танилцуулъя.

“Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл” төрийн бус байгууллага Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах Улсын Их Хурлын дэмжих бүлэг байгуулах санаачилга гарган хүсэлт ирүүлсэн билээ.

Энэ хүрээнд миний бие Улсын Их Хурлын гишүүдэд дэмжих бүлэг байгуулан хамтран ажиллах санал хүргүүлж, 19 гишүүн дэмжин гарын үсэг зурсан болно. 2024 оны 12 дугаар сарын 20-нд дэмжсэн гишүүдийг оролцуулан дэмжих бүлэг байгуулж, анхны хурлыг хийсэн.

Тус хурлаас гарсан шийдвэрээр дэмжих бүлгийн даргаар миний бие сонгогдсон болно.

Хилийн чанад дахь Монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах нийгмийн болон хууль эрх зүйн оролцоог хангах зорилго бүхий Улсын Их Хурлын дэмжих бүлгийн хүрээнд төлөвлөсөн ажлын нэг болох Хилийн чанад дахь Монгол иргэд цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах чиглэлээр судалгаа хийж санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийг ахлан ажиллах хүсэлтэй байгаа тул хүсэлтийг минь хүлээж шийдвэрлэж өгнө үү.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир гэсэн.

Тэгээд эрх зүйн хүрээнд Байнгын хороонд харьяалагдаагүй боловч Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийг ахлах боломжтой.

Тийм болохоор энэ томьёоллоороо Та бүхэнд танилцууллаа.

Ингээд “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

83.3 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв.Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Үндэсний дата төв болон И-Монгол академийн захирлын мэдээлэл

Дөрөв.Хилийн чанад дахь Монгол иргэдийн төрийн цахим үйлчилгээний И-Монгол системийг ашиглах боломж, цахимаар сонгуульд оролцох эрхийг

хангах талаар Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Үндэсний дата төв болон И-Монгол академийн захирлын мэдээллийг тус тус сонсох.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны ахлах референт Л.Мягмарсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны референт П.Алтанчимэг, И-Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга Б.Мягмарнаран, И-Монгол академийн Цахим засгийн хэлтсийн дарга Х.Энхманлай, Үндэсний Дата төв улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал М.Баттулга, Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газрын Мэдээллийн технологийн газрын дарга Э.Баттөр, Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн хүндэт тэргүүн Н.Номун-Эрдэнэ, Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын зөвлөх Б.Мөнхдөл. Б.Мөнхдөл зөвлөх байхгүй байгаа юм байна. Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын зөвлөх Б.Өлзийбат, тус байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Мөнхдэлгэр, Улсын Их Хурлын гишүүний орон тооны бус зөвлөх Ж.Жамсрандорж, Улсын Их Хурлын гишүүний орон тооны бус зөвлөх Б.Батжаргал.

Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Ингээд Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, И-Монгол академийн захирал Б.Мягмарнаран, Үндэсний дата төвийн захирал М.Баттулга нарыг энэ дарааллаараа танилцуулга хийхийг хүсье.

Тэгээд танилцуулгаа ер нь энэ юуны дэгээр 4 минут байх аа. Их Хурлын дэгээр 4 минутаар Та бүхэн товчхон гол шийдлүүдээ танилцуулчихыг хүсэж байна.

Тэгээд асуулт, хариулт дээр илүү дэлгэрэнгүй яриагаа хийгээд явчихъя.

Ингээд П.Дэлгэрнаран даргыг танилцуулгаа хийнэ үү гэж хүсье. 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

П.Дэлгэрнаран: Та бүхний энэ оройн амгаланг айлтгая.

Би гадаадад байгаа иргэдээс сонгуульд хэрхэн санал авч байгаа талаараа яг одоогийн байдлаар хууль тогтоомж маань хэрхэн байгаа, ямар байгаа, хэрхэн зохион байгуулж саналаа хураадаг талаар товч танилцуулга хийе.

Тэгээд цаашдаа авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товчхон танилцуулъя.

Гадаадад байгаа иргэд гэж хэнийг хэлэх юм бэ гэдэг хуулийн товчхон тодорхойлолтыг хэлье.

Гадаад улсад байгаа иргэдийг 6 сар буюу түүнээс дээш хугацаанд тухайн улсад оршин сууж ажиллаж амьдарч байгаа хүнийг хэлнэ гэж Гадаад улсын иргэдийн зорчих эрх, цагаачлалын тухай хуульд ингэж заасан байдаг.

Улсын Их Хурлын тухай хуульд тухайн гадаад улсад 60 буюу түүнээс дээш хоногт зорчиж байгаа иргэдийг сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэж санал авах ажлыг зохион байгуулна гэж заасан байгаа.

Бид гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн тоо баримтуудыг Та бүхэнд товчхон дурдахад Үндэсний статистикийн хорооноос 5 жил тутам гаргадаг энэ тоогоор хамгийн сүүлийн 5 жилийн тоон дээр 122 мянга 300 гэж гарсан байгаа.

Хил хамгаалах байгууллага бас энэ талын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Энэ талын мэдээллийг гаргадаг. Энд 259 мянга 562 иргэн байна гэж өгсөн. Үүнийг Сонгуулийн ерөнхий хороонд 2023 оны 12 сарын 31-ний байдлаар.

Гадаад харилцааны яам бол 229 мянга 986 гээд. Тэгээд мөн дипломат төлөөлөгчийн газруудтайгаа нэгтгээд сонгуулийн насны 187 мянган сонгогч байна гэж үзсэн байгаа.

Тэгэхээр энэ тоонууд хоорондоо байнга зөрүүтэй. Тухайн ажлыг эрхэлж байгаа байгууллагуудынх нь ажлын онцлогоос болоод энэ тоонууд байнгын зөрүүтэй байгаа. Тэгэхдээ энд яг тухайн санал хураалтын тухайн өдрөөр тогтмол тоо гаргах ямар ч боломжгүй юм билээ. Байнгын хөдөлгөөнд байдаг тоо учраас энэ ингэж явж байгаа юм.

Гадаадад байгаа иргэдээсээ Монгол Улс 2012 оны Улсын Их Хурлын сонгуулиар анх эхэлж санал авсан. Тухайн үеийн сонгууль холимог системтэй байсан учраас пропорциональ хэсэг дээрээ гадаадад байгаа иргэдээсээ саналыг авсан юм.

Энд 4276 хүн бүртгүүлээд, 2799 хүн буюу бүртгүүлсэн хүний 65.0 хувь нь өгсөн.

2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар 6233 хүн бүртгүүлээд, 4248 хүн буюу 68.0 хувь нь саналаа өгсөн.

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар 7209 хүн бүртгүүлээд, 4800 хүн саналаа өгсөн. 66.8 хувь.

2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар 7394 хүн сан бүртгүүлээд, 5568 хүн буюу 75.0 хувь нь саналаа өгч байсан.

Ингээд бид 2024 он дээр тогтож танилцуулна гэсэн бодолтой байна.

Ингээд бид гадаадад байгаа иргэдийнхээ саналыг авахдаа бид хамтарч ажилладаг байгууллагууд маань Гадаад Харилцааны Яам. Энэ санал хураалтыг Гадаад харилцааны яамны саналыг үндэслэж төв комисс, салбар комиссуудыг дипломат төлөөлөгчийн газруудад зохион байгуулж авдаг. Дипломат төлөөлөгчийн газруудтай хамтарч ажиллаж байна. Хамгийн сүүлд 2024 онд 47 дипломат төлөөлөгчийн газар дээрээс бид санал хураалтыг зохион байгуулсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын шилжилт хөдөлгөөний газартай бид хамтарч ажиллаж байгаа. Хилийн чанад дахь Монголчуудын холбоо төрийн.../минут дуусав/

Ж.Золжаргал: 4 номерын микрофон нэмж өгье.

П.Дэлгэрэннаран: Радио, телевиз гээд холбогдох байгууллагуудтай бид мэдээллээ хүргэж хамтарч ажилладаг юм.

Ингэхийн тулд 2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн пропорциональ хэсэг дээр гадаадад байгаа иргэдээсээ санал авахын тулд 47 салбар комиссыг байгуулсан. Энэ нь 47 дипломат төлөөлөгчийн газарт гэсэн үг.

Тэгэхээр энд хамгаалагдсан, нууцлалтай VPN[virtual private network] сүлжээг бид оруулсан. Энэ дипломат төлөөлөгчийн газрууддаа.

Энэ бол нэгдүгээрт иргэдэд үйлчилгээг үзүүлэх. Хоёрдугаарт, сонгогчдын нэрсийн жагсаалтыг бүрдүүлэх зориулалтаар бид Улсын бүртгэлийн ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий хороо 2024 оны сонгуулийг бэлтгэх ажлыг хийсэн. Санал хураалтын өдөр ирцийг шууд дамжуулах боломж бүрдсэн.

2024 оны сонгуульд 187 мянган сонгуулийн насны иргэд байсан гэж үзвэл энд 13 мянга 95 сонгогч саналаа өгөхөөр бүртгүүлсэн. Үүний 9768 нь саналаа өгсөн. Ингээд нийтдээ бүртгүүлсэн сонгогчдын 75 хувь нь саналаа өгсөн. 25 хувь нь саналаа өгч чадаагүй.

Эндээс харах юм жил бол ирэх тусам гадаадад байгаа иргэдийн маань тоо улам өсөж байгаа. Хэдийгээр саналаа өгөхөөр бүртгүүлж байгаа хүн болон саналаа өгч байгаа хүмүүсийн тоо өсөж байгаа боловч тэнд ажиллаж амьдарч

байгаа хүмүүсийн тоо байнга өсөж байгаа юм. Үүнийг энэ графикаар харуулсан байгаа.

Бид одоо байгаа хууль тогтоомжийнхоо хүрээнд санал хураалтыг зохион байгуулахдаа зохион байгуулалтын хувьд ямар нааштай арга хэмжээнүүд авч, аль болохоор тэнд саналаа өгч байгаа иргэд саналаа өгөх боломжоор хангагдахын тулд ямар арга хэмжээнүүдийг авах вэ гэхээр санал хураалтын өдрүүдийг бид янз янзаар тогтоосныг энэ графикаар харуулж байна. Тэр цэнхэр хэсэг нь бүртгэлийн хугацаа, ногоон хэсэг нь сурталчилгааны хугацаа, тэр улаан хэсэг нь санал өгөх өдрийг нь тэмдэглэсэн байгаа.

2012 онд нэг өдөр авч байсан бол дараагийнх нь 2013 онд 3 өдөр, тэгээд дараагийн сонгуулиудад хоёр, хоёр өдөр, 2024 онд бид хууль тогтоомжоор тодорхойлуулж 4 өдрөөр хийсэн. Тэгэхдээ бид тав дахь, хагас сайн, бүтэн сайн, нэг дэх өдрийг оруулаад, амралтын өдрүүдийг оруулаад, тэгээд сонгуулийн сурталчилгаа эхлээд 50 хувьдаа хүрсэн үед бид санал хураалтын ажлыг зохион байгуулсан.

Санал хураалтыг зайлшгүй санал хураалтын өдрөөс урьдчилж авахгүй бол дүнг гаргах боломжгүй болох гээд байдаг учраас урьдчилж авдаг гэдгийг тайлбарлая.

Дэлхийн улс орнуудтай харьцуулаад үзэх юм бол бид аль хэсэг бүлэгт багтаж байна гэдгийг Та бүхэнд харуулъя.

IDEA буюу Ардчилсан сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн тоог Та бүхэнд би үзүүлье.

Дэлхийн 217 улсаас 150 улс нь гадаадад байгаа иргэдийнхээ саналыг авдаг. Авахдаа аль хэлбэрийн сонгуульдаа хэдэн улс авч байна вэ гэдгийг Та бүхэн харж байгаа байх. Хууль тогтоох байгууллагынхаа сонгууль буюу парламентын сонгуульдаа 128 улс нь авч байгаа. Ерөнхийлөгчийн сонгуульдаа 90 улс. Ард нийтийн санал асуулгадаа 77 улс. Орон нутгийн сонгуульдаа 22 улс авч байгаа.

Санал асуулгыг авахдаа санал авах байр зохион байгуулж авдаг 111 улс байгаа. Энэ 111 улс дотор манай улс явж байгаа. Шуудангаар авдаг 55 улс байгаа. Цахимаар авдаг 17 улс байгаа. Итгэмжлэгдсэн хүнээр авдаг 18 улс байгаа. Үүний хамгийн бага тоо буюу энэ 17 улс энэ 4 төрлийн хэлбэрийг дөрвүүлэнг нь ашигладаг гэсэн үг. Тэгээд энэ 17 улсын одоо жишээлбэл Эстони, Франц, Шинэ Зеланд, Америк, Швейцар, Оман гэх мэт 17 улс цахимаар саналаа авдаг.

Тэгэхдээ хэрэглэж байгаа аргууд нь шуудангийн хэлбэрийг хослуулдаг. Сонгуулийн хуулиараа бүх эрх зүйн орчныг нь бүрдүүлдэг. Цахимаар авахдаа

хэд хэдэн төрөл. Цахим веб сайтаар хөгжүүлж авдаг. Цахим хэлбэрээр интернэт хэлбэрээр авдаг. Аппликэйшн хөгжүүлж авдаг ийм хэлбэрүүд байгаа юм.

Гадаадад байгаа иргэдийн санал хураалтыг Сонгуулийн тухай хуульд эрх зүйн орчныг нь бүрдүүлж тодорхой заалтуудыг заасан байдаг. Би үүнийг уншихгүйгээр Та бүхэнд харуулъя. Ийм заалтуудаар, ийм эрх зүйн тодорхой тодорхойлолтуудаар бид энэ санал хураалтыг зохион байгуулдаг юм.

Өнөөдрийн түвшинд бид санал хураалтын байр тавиад, тэгээд дипломат төлөөлөгчийн газрууд дээр нь салбар комиссуудыг байгуулаад, тэгээд урьдчилж бүртгүүлээд, тэгээд санал хураалтад биечлэн ирж гадаадад байгаа хүмүүсийнхээ саналыг авч байгаа.

Урьд нь 2021 оны сонгуулиас 2024 оны сонгуульд ямар дэвшил гаргасан бэ гэхээр бүртгэж байгаа процессыг цахимжуулж хоёр дахин явалт хийхгүйгээр нэг санал хураах өдрөө л шууд биечлэн ирэхээр хийсэн нь илүү дэвшилттэй болсон. Гэхдээ энэ маань бас хангалтгүй байгаа. Энэ дээр саяын хэлсэн тэр 4 төрлийн хэлбэрийг бид зайлшгүй ашиглах шаардлагатай байгаа юм.

- Цахим хэлбэр;
- Шуудан;
- Итгэмжлэгдсэн хүн;
- Цахим хэлбэрээр авахдаа 3 төрөл:
  - *веб сайтыг хөгжүүлэх,*
  - *аппликэйшн хөгжүүлэх,*
  - *шууд интернэтээр*

хураах гэсэн энэ 3 төрлийн хэлбэрийг ашиглах зайлшгүй шаардлага байгаа юм.

Тэгэхээр үүнийг бид хууль тогтоомжоор асуулыг шийдвэрлэх ёстой.

Хууль тогтоомжоо батлахын тулд эхлээд бид үүнийг судлах, шийдэл хийх, аюулгүй байдлын асуудлыг тооцох, техник хангамжийн асуудлуудыг тооцох гээд их олон урт хугацааны процесс ажил байгаа.

Одоо бид 2027 оны Ерөнхийлөгчийн сонгууль, 2028 оны Улсын Их Хурлын сонгуульд бид цахимаар саналаа өгөх боломжийг иргэдэд олгох ёстой гэж бид үзэж байгаа.

Тэгэхээр энэ цахимаар санал хураалтыг зохион байгуулах. Ерөөсөө үндсэн боломж бол бидний бүртгэлийн систем онлайн болсон байх. Одоо л улсын маань дэд бүтэц энэ боломжийн түвшинд ирж байгаа.

Тэгэхээр энэ боломжийг ашиглаад бид дараагийн сонгуулиудаар цахим сонгуулийг явуулах зайлшгүй шаардлага.../минут дуусав/

Ж.Золжаргал: П.Дэлгэрнаран даргад баярлалаа.

Одоо И-Монгол Академийн захирал Л.Мягмарнаран И-Монгол төрийн цахим үйлчилгээг гадаадад байгаа хүмүүст яаж хүртээмжтэй хэрэглэх боломжийг нээх вэ гэдэг ийм хувилбарт шийдлүүдийг Та бүхэн судалж үзсэн байх. Яг тийм шийдлүүд, боломжийг, эсвэл яагаад болохгүй байгаа гэдгийг маш товч хэлж өгнө үү. 2 номерын микрофон.

Яг нөгөө гаргасан слайдаа бүгдийг нь дагалгүйгээр жоохон цаг хэмнээд явчхаарай. Тэгээд бүгдээрээ асуулт, хариулт дээрээ дэлгэрэнгүй ярья.

Л.Мягмарнаран: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ оройн мэндийг хүргэе.

Би И-Монгол хэрэглээ. Сая Ж.Золжаргал даргын хэлсний дагуу И-Монголын хэрэглээ, нийт ерөнхий тоон үзүүлэлтийг бэлтгэсэн байгаа.

Товчхон танилцуулах үүднээс би зарим слайдуудыг алгасчихъя. Өнөөдрийн байдлаар бид бүхэн 87 байгууллагын 1263 үйлчилгээг иргэнд санал болгож байна. Өнгөрсөн хугацаанд буюу бид 2020 оны 10 сарын 02-нд анх И-Монголынхоо веб хувилбарыг танилцуулснаас хойш 65 сая үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэсэн байгаа.

Одоогийн байдлаар сард дунджаар 1.9 сая үйлчилгээг иргэн, хуулийн этгээд тогтмол авч байна.

1.9 сая энэ үйлчилгээг 520 мянга орчим идэвхтэй хэрэглэгч ашиглаж авч байгаа.

Ж.Золжаргал: Уучлаарай. Л.Мягмарнаран дарга аа, Та гадаадад байгаа иргэдийг яаж И-Монгол ашигладаг болох талаараа шууд ярьчих. Тэгэх үү?

Л.Мягмарнаран: Энэ хэрэглэгчийн тоог бид энд хэлэх нь зүйтэй байх. Бид одоогоор 1 сая 950 мянган хэрэглэгчтэй болсон. Өөрөөр хэлбэл бид насанд хүрсэн иргэдийн 87 орчим хувьд бид төрийн үйлчилгээ хүргэж байгаа гэж үзэж байгаа.

И-Монголын хандалтын хувьд гадаадаас багагүй хандалттай. Нэг сарын хугацаанд 653 орчим сая хандалтыг авдаг. Үүнээс зөвхөн гадаад улсаас 7 сая орчим хандалт байгаа. Тэгэхдээ энэ бол хандалтаар нь бид хамгийн өндөр хандалттай улсуудыг ялгаж үзүүлсэн байгаа. Энэ хандалтын цаана нэг

хэрэглэгч нийт хандалтаараа 5-аас 20 хүртэлх төрлийн мэдээллийг татаж авч үздэг.

Тэгэхээр давхардсан тоогоороо хасах юм бол хэрэглэгчийн тоо буурна. Тэгэхдээ гадаадад байгаа хэрэглэгчийн хувьд 7 сая орчим хандалтыг зөвхөн нэг сард үүсгэж ашиглаж байгаа. Аппликэйшн хувилбарыг бид бас хэрэг болох болов уу гэдэг үүднээс И-Монгол аппликэйшнийг IOS[iPhone Operating System] болон Android үйлдлийн систем дээр татаж авсан төлбөрүүдийг улсуудаар нь ялгаж үзүүлсэн байгаа. Та хэд бас авч үзээрэй. Энэ дээр аль аль улс хамгийн өндөр хэрэглээтэй байгаа талаарх мэдээллүүдийг оруулсан байгаа.

И-Монголиагийн хувьд бид хэрэглэгчид ерөнхийдөө яг нэвтэрч ороход нь 3 төрлийн хандах боломжийг санал болгодог.

- Нэгд, тоон гарын үсгээр эргэн нэвтрэх;
- Хоёрт нь, интернэт банкны эрхээр нэвтрэх;
- Гуравт нь, өөрийн нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаараар нэвтрэх

гэсэн сонголт байдаг.

Гадаадад байдаг иргэдийн хувьд түрүүн дурдсан удаан хугацаагаар байж байгаа иргэдийн хувьд хамгийн түгээмэл нь интернэт банкны эрх болон өөрийн нэр дээрээ LIME[Landline, Internet, Mobile, Entertainment] ч юм уу, онлайн ч юм уу онлайн операторын дугаарыг бүртгэл дээр бүртгэж ашиглаж байгаа.

Мөн дээр нь сонирхуулахад бид бүхэн Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран операторын киоскуудыг бас байршуулсан байдаг.

Хилийн чанад байршсан 49 хурдан цэг оператор байршуулсан байдаг. Тэгээд энэ дээр байршсан улсуудыг бас оруулсан байна. Өөрөөр хэлбэл тухайн үйлчилгээний цэг дээр иргэн өөрийн биеэр очоод төрийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн байдаг. Хэдийгээр ийм боломж байдаг ч гэсэн хэрэглээ маш багатай. Мобайл аппликэйшн бол 85 хувийн хэрэглээтэй байдаг бол веб 13 хувь, оператор болон киоскоор ер нь иргэдийн бол 2 хувь энэ үйлчилгээг авч байгаа.

Тэгэхээр бид нарын гол санал болгож байгаа зүйл бол тоон гарын үсгээр нэвтэрч орох нь хамгийн зүйтэй гэж үзэж байгаа. Яах вэ, тоон гарын үсэгтэй холбоотойгоор энд зүгээр статистик үзүүлэхэд тоон гарын үсэг маань өөрөө 2 төрөл байгаа. Иргэн болон хуулийн этгээдэд зориулсан 2 төрлийн одоо гарын үсэг байгаа.

Хуулийн этгээдийн хувьд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас тусгай зөвшөөрөл бүхий 5 аж ахуйн нэгж байдаг. Тэд нараас хүлээж

авсан USB Token хэлбэр дээр цахим гарын үсгээ авдаг. Тэр төрлийн цахим гарын үсэг. Энэ нь ESIGN гэж байгаа. Улсын бүртгэлийн ерөнхий газраас иргэнд олгодог GSIGN гээд цахим гарын үсгийн хэрэглээг энэ дээр бас бүртгэж оруулж өгсөн.

Тэгэхдээ нийлбэр дүнгээрээ харахад GSIGN буюу Улсын бүртгэлийн ерөнхий газрынх 884 мянга орчим хэрэглэгч бүртгүүлсэн байна. Хуулийн этгээдийн хувьд 67780 байгаа.

Гэхдээ энэ дээр нэг юмыг хэлэхэд Улсын бүртгэлийн ерөнхий газрынх хэрэглэгчид олгож байгаа цахим гарын үсгийн төрөл маань өөрөө 2 төрөл байгаа.

Нэг нь, иргэний үнэмлэх дээр бичилтээр хийж өгч байгаа.

Нөгөөдөх нь, тухайн иргэн өөрөө GSIGN мобайл аппликэйшнийг.../минут дуусав/

Ж.Золжаргал: 2 дугаар микрофон нэмж өгье.

Б.Мягмарнаран: GSIGN мобайл аппликэйшн дээр өөрийн цахим гар үсгээ идэвхжүүлээд ашиглах боломжийг бүрдүүлсэн байгаа.

Тэгэхээр хэдийгээр бид энэ олон хэрэглэгч байгаа юм шиг боловч энэ 880 мянга орчмын бараг 100 мянга орчим хүрэхгүйн л иргэн cloud хэлбэрээр GSIGN аппликэйшнийг ашиглаж байгаа. Иргэд иргэний үнэмлэх дээрээ маш ихээр бичүүлсэн байдаг.

Тэгэхээр иргэний үнэмлэхийн хувьд хэрэглээ байдаггүй. Иргэний үнэмлэх уншигч байдаггүй үүднээс энэ хэрэглээ хангалтгүй байгаа юм. Тийм.

Ерөнхийдөө ийм танилцуулга байгаа. Тэгээд дараа нь нэмэлт хариулт өгөөд явчихъя. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой Үндэсний дата төвийн захирал М.Баттулга таныг хураангуй мэдээлэл өгнө үү гэж хүсье. 3 дугаар микрофон.

М.Баттулга: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг хүргэе.

Ер нь Монгол Улсын цахим шилжилт нэлээн эрчимтэй явагдаад мэдээлэл солилцооны үндсэн систем дээр өнөөдрийн байдлаар 816 төрлийн төрийн үйлчилгээний сервисүүд гарснаар цахимаар төрийн үйлчилгээг авах энэ боломж

бүрдсэн байгаа. Өөрөөр хэлэх юм гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэд 816 төрлийн төрийн үйлчилгээг цахимаар авах боломж бүрдсэн байгаа.

Үүн дээр гадаадад байгаа иргэдийг ер нь цахимаар яаж таних вэ гэдэг энэ шийдэл бас нэлээдгүй хурцаар тавигдаж байгаа.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль дээр цахим орчинд иргэнийг таньж баталгаажуулах системийг “ДАН” систем гэж хуульчилж өгсөн байгаа. “ДАН” системийн ашиглалт үйлчилгээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хариуцаж ажиллахаар байгаа.

Системийн хувьд мэдээлэлд хандах эрх, мэдээллийн сан, дэд бүтэц, хөгжүүлэлт, мэдээлэл дамжуулах гэсэн энэ бүх процессыг өнөөдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Үндэсний дата төв хариуцаж ажиллаж байна.

“ДАН” системийн хувьд анх энэ сервисүүд онлайн болсноор иргэнийг цахим орчинд хамгийн өндөр хувьтайгаар таних зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн. Энэ хүрээнд 2018 онд “ДАН” систем анх хөгжүүлэгдээд анх нэг удаагийн код буюу иргэний регистр дээр бүртгэлтэй гар утасны дугаар луу нэг удаагийн код илгээх зарчмаар хэрэглэгчийг бүртгэж байна.

2020 онд банкны эрх, тоон гарын үсгийг шинээр нэмж оруулсан.

2022 онд клауд тоон гарын үсгийг нэмж оруулаад, мөн гадаадад оршин суугаа иргэдийг энэ LIME операторын онлайн дугаараар таних боломжийг бүрдүүлсэн байгаа.

Ингээд 2024 онд дэд бүтцийн кластер архитектурын хувьд шинэчлээд 2024 онд бид сүүлийн үед “ДАН” дээр гараад байгаа асуудлуудыг нэлээдгүй цэгцэлсэн.

2025 онд энэ веб суурьтай системийг илүү аппликэйшн суурьтай, тусдаа бие даасан, мөн гадаадад оршин суугаа иргэдийг таних олон шийдлүүдийг нэвтрүүлсэн ийм систем болгож хөгжүүлэхээр төлөвлөөд ажиллаж байна.

Технологийн хувьд Пайд Нэйл дээр бичсэн. WebSocket-д бол “ө аут протокол”-оор мэдээлэл солилцдог. Технологийн хувьд кластер байдлаар зохион байгуулсан.

Ачаалал өссөн үед өөрийгөө өргөтгөөд явах боломжтой ийм систем байгаа.

Статистикаас дурдах юм бол төрийн 88 байгууллагын 176 систем, хувийн хэвшлийн 234 байгууллагын 271 систем. Нийтдээ 2.1 сая хэрэглэгч, 74 сая

удаагийн нэвтрэлтийг энэ ДАН системээр. Эдгээр нь төр, хувийн хэвшлийн 300 орчим систем рүү нэвтэрсэн.

Өөрөөр хэлэх юм бол ДАН системийн хэрэглэгч болоод бүртгэгдээд ороод ирэх юм бол гадаад, Монголд оршин суугаа бүх иргэд үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.

Нэг удаагийн кодоор 34 сая удаа нэвтэрсэн байна. Өнөөдөр Монгол Улсад 1.4 сая хэрэглэгч албан ёсоор тоон гарын үсэг авсан байна. Үүнээс 2 сая 399 мянга нь одоо энэ ДАН систем дээр тоон гарын үсгээ ашиглаж нэвтэрсэн байна.

Банкны эрхээр 37 сая хэрэглэгч нэвтэрсэн. ТҮЦ машинаар өөрийгөө нэлээн өндөр хувьтай биометрик өгөгдлөө баталгаажуулаад энэ ДАН системийн хэрэглэгч болж нэвтэрч байгаа. Үүгээр 4600 хэрэглэгч нэвтэрсэн байна. Мөн энэ ДАН системээр дамжуулаад Монгол Улсын иргэдийг танихаас гадна И-Монгол академи, иргэн харьяаттай бид хамтраад Монгол Улсад нэвтэрч байгаа гадаадын иргэдийг бас таних энэ шийдлийг нэвтрүүлсэн.

Монгол Улсад бас гадаад захиралтай аж ахуйн нэгжүүд бас нэлээн байдаг.

Тэгэхээр эдгээр хүмүүс маань тендерт орох, тайлан төлөвлөгөөгөө өгөх, тоон гарын үсэг авах гэх мэт үйл ажиллагаанууд нэлээн хүндрэлтэй байсан. Энэ асуудлыг энэ F-Register гэдэг асуудлаар шийдээд өнөөдрийн байдлаар 742 мянган гадаадын иргэнээс 1221 нь яг энэ ДАН системийн хэрэглэгч болж нэвтэрсэн байна гэсэн ийм статистик байна.

Системийн хувьд тулгарч байгаа асуудал яг энэ гадаадад амьдарч оршин сууж байгаа иргэд маань өөрийн нэр дээр гар утасны дугааргүй, банкны эрхээрээ бас төдийлөн нэвтрэх хүсэлгүй. Дээрээс нь LIME-ийн операторын дугаар авах энэ боломжгүй гэсэн ийм бас нэлээдгүй асуудлууд байдаг.

Тэгэхээр эдгээр иргэдийг өөр шийдлээр системийн хэрэглэгч болж төрийн үйлчилгээг хүргэх хэрэгцээ шаардлага тулгарч байгаа. Мөн мэдээлэл хандах түвшний энэ асуудал байгаа.

Бид бас энэ ДАН систем дээр олон улсын зөвлөмж буюу Эстонийн Цахим засаглалын академиас бас зөвлөмж авсан. Энэ дээр Кэй пойнт, энэ 5 төрлийн зөвлөмжөөс 4-ийг нь хэрэгжүүлээд ажиллаж байна.

ДАН системийн шинэчлэлийн хувьд OTP[One-Time Password] буюу нэг удаагийн кодоор нэвтрэх, банкны эрх, тоон гарын үсгээр нэвтрэх. Энэ нөгөө царай танилтаар зайнаас иргэнийг таних шийдлийг нэвтрүүлэхээр зорьж байна.

Нэмэлт боломжуудын хувьд тоон гарын үсгээр ашиглаад ДАН систем дээр тоон гарын үсгийг интеграц хийснээр цахим баримт бичиг дээр гарын үсэг зурах, магадгүй цаашлаад сонгуулиа өгөх ч юм уу. Тийм ээ. Энэ боломжуудыг бий болгоно. Мэдэгдэл хүлээн авах, иргэний мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах энэ боломжуудыг бас бий болгоно. Минут тутамд солигдох токен буюу google authenticator шиг ийм токеныг бас нэмэлтээр бий болгоно. Системийн илүү user брэндийн байдлыг нэмэгдүүлэх үүднээс смарт утас.../минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмэлт цаг өгье. 3 дугаар микрофон.

М.Баттулга: Смарт утасны өөрийнхөө биометр өргөдлүүдийг ашиглаад нэвтрэх боломжуудыг бий болгоё гэж байгаа.

Ер нь Монгол Улсад хуулиараа яг албан ёсны хүлээн зөвшөөрөгдөж байгаа нь тоон гарын үсэг.

Тэгэхээр бид энэ систем дээрээ цаашдаа ер нь тоон гарын үсгийнхээ хэрэглээг илүү шахаад явна. Системийн хэрэглэгч болоод одоо өнөөдрийн байдлаар нэг удаагийн код, банкны эрх, тоон гарын үсгээр нэвтэрч байна. Энэ бүх түвшний хэрэглэгчид яг адилхан түвшний үйлдэл хийгээд байгаа.

Тэгэхээр цаашдаа магадгүй сонгууль өгөх, гэрээ хэлцэл байгуулах, үл хөдлөх хөрөнгөө шилжүүлэх ч гэдэг юм уу энэ түвшинд бид энэ систем дотроо 3 түвшний хэрэглэгчээр ангилж өгье гэж байгаа юм. Биометрик өгөгдлөөр нэвтрээд орох юм бол мэдээллээ нэгдүгээр түвшин буюу өөрийнхөө мэдээллийг харах. Хоёрдугаар түвшиндээ бас тодорхой хэмжээний үйлчилгээнүүд.

Тоон гарын үсгээр нэвтэрсэн тохиолдолд full эрхтэйгээр үйлчилгээ авдаг боломжийг бүрдүүлнэ гэж байгаа.

Тоон гарын үсгийг гадаадад байгаа иргэдийн хэрэглээг яаж нэмэгдүүлэх вэ гэх юм Гадаад харилцааны яамны 47 төлөөлөгчийн газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын энэ цэгүүд үйлчилгээний төвүүдийг ашиглаад тоон гарын үсгийн олголтыг нэмэгдүүлье гэж байгаа.

Дээрээс нь бид энэ LIME операторын үйлчилгээг бас илүү түлхүү хүргэе. Мөн биометрик өгөгдлөөр зайнаас баталгаажуулах энэ хиймэл оюун ухаанд суурилсан шийдлийг 2025 онд ДАН системийнх нь хөгжүүлэлт дээр нэмж оруулна гэсэн ийм төлөвлөгөөтэй ажиллаж байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Танилцуулга хийсэн хүмүүстээ баярлалаа. Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан хүний сонгох, сонгогдох эрх хамгийн чухал суурь эрхүүдийн нэг.

Тэгээд энэ эрхийг эдлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь төрийн үүрэг. Нөгөө талаасаа одоо бид чинь ингээд бараг 2 аймагтай дүйцэхүйц хэмжээний Монголын иргэд дэлхийгээр нэг тарчихсан байдаг. 5 хувь нь ойролцоогоор л сонгуульдаа орж байдаг.

Тэгэхээр энэ өдий болтол яг төрийн суурь үүргээ хэрэгжүүлэх тэр том хийдэл гарч ирсний л илрэл гэж үзэж байна л даа. Одоо ингээд техникийн бааз суурь бол бас хангалттай хэмжээний түвшинд Монгол Улсад хөгжчихжээ.

Тэгэхээр энэ эрхийг эдлүүлэх нь цахим байна уу, хосолсон байна уу, шуудан байна уу тэр бол хоёрдугаар асуудал. Ямар ч байсан үүнийг эдлүүлэх цаг нь болсон байна. Нэгэнт дэлхий нийтээрээ ингээд цахим технологи өргөн ашиглачихсан үед бид боломж эрсдэлээ дэнсэлж байгаад шийдвэрээ гаргах шаардлага болчихсон байгаа.

Хоёрдугаарт нь, энэ И-Монгол академи цахимжилт бол үнэхээр сүүлийн хэдэн жил Монголд сайн явсан. Тэгэхдээ бид чинь дахиад л нөгөө дэлхийгээр нэг тарчихсан. Хэдийгээр хандалт нь өндөр байгаа ч тэд нар Монголд нэг үүрийн телефоны операторгой гэрээтэй хүмүүс л хэрэглээд байна шүү дээ. Тэгээд бусад нь хэрэглэх шийдлийг одоо бас л нэвтрүүлэх цаг нь болчихжээ. Тэгээд энэ дээр нэг их айхтар эрх зүйн орчны тохиргоо байх уу, эсвэл зүгээр ажлын шугамаар шийдчих үү. Үүнийг л бид өнөөдөр гол нь бас ярилцах зорилготой.

Тэгээд гол нь цахим сонгуультай холбоотой асуудлаар Улсын Их Хурал, Инновац, цахим бодлогын байнгын хорооноос ажлын хэсэг гараад ажиллана.

Тэгэхээр Та бүхэндээ холбогдоод дэлгэрэнгүй мэдээллүүдээ ажлын шугамаар аваад явна.

Ингээд саяын өгсөн мэдээлэлтэй холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ж.Галбадрах гишүүний микрофоныг нээж өгье.

Ж.Галбадрах: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Иргэдээ бид сонгуульд цахимаар оролцуулна гэдэг үнэхээр том дэвшил болно. Монголчууд маань гадаадад байгаа, би ч өөрөө бас гадаадад байсан. Тэгээд яалт ч үгүй л Токиод санал асуулга авдаг. Миний амьдарч байгаа хот хол байдаг. Зардал мөнгөнөөс эхлээд янз бүрийн асуудлаар амьдарч байх үедээ сонгуульд оролцож чадаж байгаагүй. Очиж нөгөө юу яахаар.

Тэгэхээр бид яалт ч үгүй л монголчууд маань өөрсдөө сонгуулийн идэвх их сайтай. Тэгээд гадаадад байж байгаа иргэд маань юу гэдэг юм өөрийн дураар явна гэхээсээ илүү тэнд сурах, ажиллах гэсэн ийм асуудлуудаар их идэвхтэй хүмүүс тэнд байдаг учраас энэ цахимаар авна гэдэг их чухал гэж бодож байна. Тэгээд 200-аад мянган иргэн байгаа юм байна. Тэгээд жилээс жилд өсөж байгаа юм байна.

Тэгэхээр энэ өсөлтийг тооцоод үүнийг даруй хийх байх. Сая Сонгуулийн ерөнхий хорооны даргын юунд 2027, 2028 оны сонгуулийг хэрэгжүүлэх зорилт тавьж байгаа гэж байна. Тэгээд энэ талаар ямар үе шаттай бэлтгэл ажлуудыг ер нь хийж байгаа вэ гэдгийг нэгдүгээрт сонирхоод асууя.

Тэгээд ер нь судалгаа байна уу? Хэдэн хувь нэмэгдэх бол? Одоо энэ дөнгөж 7 хувьтай. Тэгээд 7 хувийнх нь дотроос нь өгч байгаа гуравны хоёр нь. Тийм ээ. Дөрөвний гурав нь энэ 75 хувь нь өгч байгаа юм байна. Тэгвэл энэ хувь нэлээн өсөх байх. Тэгэхдээ би бас нэг хэдэн хувь болох бол, энэ цахимаар өгөхөөр гэдэг нийт хүмүүсийн бас нэг мэдээллийг Та нарт судалгаа байдаг бол сонсмоор байна.

Тэгээд тэр аюулгүй байдал, эрсдэлийн талаар технологийн шийдлүүдийн талаар сая нэлээн мэдээлэл авлаа. Тэгээд ер нь тэр хүнээ таних гэдэг зүйл, тэр өөрөө яг өгч байна уу, бусдын юу гэдэг юм хараа хяналтад орчихсон өгч байна уу гэдгийг л бид мэдэж авах нь хамгийн чухал байгаа.

Түүнээс гадна сонгууль өгөхгүй хүн гадаадад их гарчихсан хүмүүс байдаг. Хилийн хориотой мөртлөө гараад явчихсан байж байдаг. Эрэн сурвалжлагдаж байгаа хүмүүс ч гэсэн ингээд гадаадад амьдраад явж байгаа шүү дээ. Энэ хүмүүс, тиймэрхүү зөрчилтэй иргэдийн асуудлыг яаж шийдэх юм. Тэр талаар ямар бодолтой байгаа вэ гэдгийг энэ асуумаар байна.

Тэгээд ер нь шилжилт хөдөлгөөн, энэ сонгууль болохоор л Монголд царцаа гээд хүмүүс явдаг шүү дээ. Орон нутаг руу яваад сонгууль өгдөг. Тэгвэл энэ цахим царцаанууд дээр үүсэх эрсдэлүүд ямар байдаг юм. Тийм ээ. Тэр талаар сонирхож асууж байна. Ийм асуултууд байна.

Ж.Золжаргал: Ж.Галбадрах гишүүний асуултад хариулах уу? 4 дүгээр микрофон нээж өгье.

П.Дэлгэрнаран: Ж.Галбадрах гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ цахим сонгуулийн хууль тогтоомжийг батлах шийдлийг хийхэд их олон процесс ажил орно.

Тэгэхээр эхний удаа Байнгын хороогоор ороод эндээс ажлын хэсэг байгуулагдах гэж байгаа маань одоо бид нарыг их баярлуулж байгаа. Энэ бол эхний ажил хөдөлж эхэлж байгаа ажлын эхлэл байгаа юм.

Тэгэхээр бид энэ цахим сонгуулийн хэлбэрийг хууль тогтоомжид оруулах шийдлийг, санал хураалтыг зохион байгуулах шийдлийг Сонгуулийн ерөнхий хороо дангаараа хийх боломжгүй. Шууд хуульд хүчээр тусгах бас боломжгүй.

Тэгэхээр үүний цаана олон процесс ажил байгаа. Техникийн хувьд боломжтой эсэх, энэ дэд бүтцийн хувьд хэр зэрэг байх, үүний аюулгүй байдлын баталгаа хэр зэрэг байх, орон зайн хувьд ямар орон зайд байх вэ энэ тэр гээд энэ бүх зүйл дээр дүгнэлт, шинжилгээ судалгаанууд хийгдээд ингээд энэ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, тагнуулын байгууллагуудаас энэ аюулгүй байдлын баталгааны дүгнэлт гарч тэгээд дараа нь үүнийг хууль тогтоомжийн төсөл боловсруулагдаж өргөн баригдаж явна. Үүнтэй зэрэгцээд нийгмийн зөвшилцөл хийгдэх ёстой.

Өөрөөр хэлбэл сонгуулийн энэ хэлбэрүүдийг хууль тогтоомжид тусгаж цаашид хэрэглэх асуудлаар улс төрийн хүрээнд, нийгмийн хүрээнд зөвшилцлийг зайлшгүй хийх шаардлагатай болдог.

Ингэхээр энэ олон процесс ажлуудын хамгийн эхлэл болсон өнөөдөр ажлын хэсэг байгуулагдаад явах гэж байгаад бид их баяртай байгаа.

Тэгэхээр бид энд одоо дараагийн сонгууль хол байна гэж тайвширч болохгүй. Хугацаагаа маш шахуу үе шаттайгаар амжуулаад явбал бид 2027, 2028 оны үед хамгийн гол нь энэ цахим дэд бүтцийн асуудал нэлээд их наашгай байгаа ийм үед зүгээр гэж үзэж байгаа.

Тэгэхээр бид энэ ажлуудыг үе шаттай аваад явахад амжих байх гэсэн урьдчилсан тооцоолол байна.

Энэ сонгогчдын нэрсийн жагсаалтын бүртгэл, сонгогчдын бүртгэл цахим онлайн болоод, энэ нь зохих түвшинд хамгаалагдсан ийм болсон үед царцаа гэдэг асуудал утгагүй. Энэ бол автомат байхгүй болно. Ялангуяа биечлэн нүүдэг царцаа бол ямар ч хэрэггүй. Цахим царцаа гэж гарч ирэх боломжгүй гэж би үзэж байгаа.

Тэгэхээр царцаа гэдэг асуудал нэгмөсөн үгүй болоод. Ингээд хамгийн гол нь бид орон зайн хувьд ямар орон зайд байх юм бэ гэж байгаа. Одоогийн байдлаар Оросын Холбооны Улс маш том газар нутагтай. Тэгсэн мөртөөсөө дотооддоо зайнаас санал өгөх ийм.../минут дуусав/

Ж.Золжаргал: 4 номер. Нэмэлт цаг өгнө.

П.Дэлгэрнаран: Ингээд энэ асуудлаа шийдээд яваад байгаа. Гэхдээ тэднийх гадаад улсуудаас цахимаар интернэтээр авдаггүй. Энэ бол аюулгүй байдлаа хангаж чадахгүй. Энэ хязгааргүй орон зайд байдаг энэ интернэтийг яг энэ хязгааргүй хэлбэрээр нь бид ашиглах боломжгүй. Тодорхой орон зай, хүрээлэлд байлгана гээд ингээд явдаг.

Манайх бас үүнийхээ аюулгүй байдлыг хангаж чадах уу, үгүй юу гэдэг асуудал мэргэжлийн улсууд дүгнэлт гаргаж энэ дээр тодорхой юм хэлэх байх гэж бодож байгаа. Баярлалаа.

Ж.Золжаргал: Нэмэлт хариулт байхгүй. Та Ж.Галбадрах гишүүн болсон уу? Ж.Галбадрах гишүүний микрофон нээж өгнө үү.

4 дүгээр микрофон нээж өгье.

П.Дэлгэрнаран: Ж.Галбадрах гишүүний асуулт дээр тэр хэрэг төвөгт орсон, одоо гадаадад ажиллаж байгаа зарим улсууд сонгуульд орох сонирхолгүй, орох боломжгүй болчихдог гэж. Тэр бол яг бодитой байгаа. Яг өнөөгийн шалтгаан.

Сая 100 гаруй мянга гэж яриад байгаа улсуудын маань ихэнх хэсэг нь энэ дээр байгаа юм. Тэгээд бичиг баримтын зөрчилтэй. Тэгээд зарим нь өөрсдийнхөө нууцлалыг хийхгүй гэдэг. Зарим нь харласан байдаг. Гэмт хэрэгт холбогдсон байдаг. Ийм улсууд орох сонирхолгүй. Тухайн дипломат төлөөлөгч. Ялангуяа өнөөдрийн хэлбэрээр санал хураах юм бол бүүр ирэх сонирхолгүй.

Дипломат төлөөлөгчийн газрууд хамгаалагдсан хараа хяналтад орсон байдаг учраас тэр лүү ойртохыг хүсдэггүй. Интернэт санал хураалт цахимаар авдаг болсон үед бас тодорхой хэсэг нь боломж олдох байх гэж үзэж байгаа.

Одоо үндсэндээ хамгийн идэвхтэй хэсэг энэ алс холоос ч гэсэн, улс дамжаад ч гэсэн ирээд саналаа өгч байгаа энэ иргэддээ талархах хэрэгтэй.

Ж.Золжаргал: Д.Бум-Очир гишүүний микрофоныг нээж өгнө үү.

Д.Бум-Очир: Та бүхэнд оройн мэнд хүргэе.

Хамгийн санаа зовоож байгаа асуулт бол хамгаалалтын асуудал гэж ойлгож байна. Сая бас энэ асуудал дурдагдлаа.

Бид цахимаар сонгуулийн санал хураалт явуулах бэлтгэл хийгдсэн байгаа гэж үзвэл энэ агуулга дотор нөгөө цахимаар санал өгөхөд түүнийг хамгаалах хамгаалалтыг нь бид ярьж байна уу, ярихгүй байна уу? Энэ хоёр тусдаа асуудал юм уу, нэг асуудал юм уу? Жишээ нь, Сонгуулийн ерөнхий хороо, И-Монголиа, ДАН гээд. Бид цахимаар ямар ч байсан саналаа авчхаж

болох юм байна. Техникийн болоод технологийн дэд бүтцийн юмнууд бүрдчихжээ гэж үзье. Бүрдчихжээ гэж бид ярьж байгаа нь хамгаалалтын систем нь бас давхар бүрдчихсэн байгаа гэдгийг оруулж ярьж байна уу, оруулахгүй ярьж байна уу гэдгийг бодмоор байна. Нэгд.

Ер нь энэ хамгаалалтын системийг хэн хийх юм? Манай үндэсний байгууллага хийх юм уу? Олон улсын ийм хамгаалалтын дэлхийн жишиг гүйцсэн систем байдаг юм уу? Тэр хийх юм уу? Ер нь энэ хамгаалалттай, найдвартай, гаднын ямар нэгэн улс орнуудын болоод дотоодын хаанах ч байдаг юм халдлага мэдээж хийгдэнэ. Одоо ч гэсэн манай юмнууд хийгдэж байгаа шүү дээ. Гэхдээ халдлагад өртөж чадаж байна уу, үгүй юу, өртөж байна уу, үгүй юу гэдэг нь тусдаа асуудал л даа.

Тэгэхээр халдлагад бол өртөх нь тодорхой. Тэр өртөж байгаа халдлагаас хамгаалах боломжтой гэдэг нотолгоо баталгааг хэн яаж гаргаж өгөх юм бэ яаж мэдэх юм бэ? Яаж мэдэх юм бэ? Энэ бол олон нийтийн болоод гишүүдийн асуух хамгийн их асуух асуулт болов уу гэж би бодоод байна л даа.

Тэгэхээр энэ бусад Эстони энэ тэр гээд цахимаар саналаар сонгуулиа явуулж байгаа улс орнууд энэ баталгаагаа яаж хангадаг юм бол. Энэ дээр Та бүхний хэн нь хариулах юм бол?

Сая хэлж байна л даа. Энэ бол авчихна. Гэхдээ хамгаалалтын тухай асуудал гээд яригдаад өнгөрсөн. Энд хариулах субъект нь хэн байх юм? Технологийн талаасаа. Энэ дээр нэгэнт хариулт авмаар байна.

Үг хэлэх нь хамт явж байгаа юу? Зөвхөн асуулт явж байгаа юу? Би үг хэлэхээ дараа нь авчихъя.

Ж.Золжаргал: 4 номер. П.Дэлгэрнаран дарга.

П.Дэлгэрнаран: Д.Бум-Очир гишүүний зарим асуудлууд дээр тодруулга хийе.

Д.Бум-Очир гишүүний хэлж байгаа тэр цахим сонгууль гээд. Жишээлбэл, Эстони цахимаар шууд саналаа бүгдээрээ өгдөг юм шиг яригдаж байгаа. Энэ бол тийм биш. Эстони 1 сая орчим сонгогчидтой. Хүн ам их цөөхөн улс. Тэгэхдээ цахимжилтаараа дэлхийд тэргүүлж байгаа. Үйлчилгээнийхээ цахимжилтаар ийм улс. Жишиг болсон улс. Гэхдээ тэнд цахим сонгуулийн санал хураалт бол нэг л хэлбэр нь. Санал хураалтын нэг хэлбэрээр ашиглагдаж байгаа.

Тэгээд энд нийт сонгогчдын 47 хувь нь. Дэлхийн хамгийн өндөр үзүүлэлт. Процентоор нь үзвэл 47 хувь нь.

Тэгээд түрүүний миний хэлсэн 17 улс доошоогоо 20 хэдэн хувь, 7, 8 хувь, 10 хэдэн хувиар ингэж өгч байгаа юм. Яг өнөөдрийн байдлаар 100 хувь интернэт цахимаар саналаа хурааж байгаа улс нэг ч байхгүй.

Тэгэхээр цахим санал хураалт сонгогчдын саналаа өгөх нэг л хэлбэр байх юм. Манайд бид нарын төсөөлж байгаагаар яг одоогийн байгаа энэ уламжлалт хэлбэр төхөөрөмжөө ашиглаад өөрөө санал хураалтын байранд өөрөө ирээд саналаа өгч байгаа энэ бол үндсэн арга хэлбэрээрээ л байна.

Цахимаар санал өгөх асуудал нэг сонголтын хэлбэр болж шинээр орж ирэх ёстой гэж ингэж үзэж байгаа.

Энэ хамгаалалтын хувьд зэрэг явагдах ёстой. Шийдэл, хамгаалалт, бүх зүйл явах ёстой.

Би мэргэжлийн биш хүний хувьд мэргэжлийн биш учраас нэг их нарийн хэлж мэдэхгүй байна. Тэгэхдээ бид бусад улсуудын энэ цахим санал хураалт явж байгаа процессыг бүдүүвчлээд аваад үзээд, харьцуулаад судлаад үзэхээр эд нар бол одоо манайхны зарим хэсэг нь банкны төлбөр, гүйлгээ хийж байгаатай их адилтгаж ярьдаг. Энэ бол биш ээ. Банкны гүйлгээ бол их тоотой мөнгө явуулж байгаа ч гэсэн эцсийн хүлээн авагч нь бүх зүйлийг баталгаажуулаад хэлээд байдаг учраас болохгүй.

Энэ бол эцсийн хүлээн авагч нь тухайн сонгогч би хэнд саналаа өгснөө мэднэ. Эцсийн хүлээж аваад дүнг тоолж байгаа асуудлыг бол хэн ч мэдэж чадахгүй. Тэгэхдээ энэ зөв тоологдох ёстой. Зөв тоологдож, ямар ч алдаагүй гарч ирэх ёстой.

Тэгэхээр энэ дээр технологи ашиглаж таарч байгаа юм. Технологи ашиглана. Тэгэхээр технологийн компанитай хамтарч ажиллаж таарна. Тэгээд мөн аюулгүй байдлын асуудлыг манай улс өөрсдөө хангах ажлыг хийх болов уу гэсэн ийм төсөөлөл байна. Би тэгэхдээ мэргэжлийн хүний хувьд биш учраас би сайн хэлж чадахгүй байна. Зүгээр энэ ажил зэрэг хийгдээд явах ёстой гэж бодож байгаа.

Технологийн компанийг ашиглана гэхээр, технологи ашиглана гэхээр хардлага бол ёстой айхтар дагуулна. Одоо энэ уламжлалт аргаас илүү хардлагыг дагуулна.

Тэгэхдээ энд маш анхааралтай хандахгүй болохгүй. Олон улсын байгууллагуудаас.../минут дуусав/

Ж.Золжаргал: Та нэмэлт цаг авах уу? 4 номер. Нэмэлт 1 минут.

П.Дэлгэрнаран: Олон улсын байгууллагуудаас бид нарт юу гэсэн зөвлөмж өгч байгаа вэ гэхээр цахим сонгуулийн бэлтгэлээ бол маш сайн хангаж орно шүү. Цахим сонгуулийн бэлтгэлээ сайн хангаагүй, алдаагүй, аюулгүй болгож байж орохгүй бол цахим сонгуулийн нэр хүндээ та нар сонгогчдынхоо эцэстээ сонгууль гэдэг бол сонгогчдын итгэл найдвар, итгэл үнэмшил байдаг. Энэ итгэл үнэмшлийг алдвал тэгээд цахим сонгууль чинь тэр чигээрээ танайд байхгүй болно шүү.

Тийм учраас цахим сонгуульдаа хугацаанд яарах хэрэггүйгээр маш сайн бэлдэж ороорой гэдэг ийм зөвлөмжийг өгч байгаа юм. Баярлалаа.

Ж.Золжаргал: Тодруулга авна. Д.Бум-Очир гишүүн.

Д.Бум-Очир: Баярлалаа. Тэр тайлбар тодруулга хийсэнд баярлалаа. Бас цахим санал хураалт бол зөвхөн нэг хувилбар нь гэдгийг ойлгож байгаа.

Яг үүнтэй холбогдуулаад нэг зүйлийг асуучихъя. Гадаадад байгаа, ялангуяа Америк, Солонгост олон монголчууд байгаа. Олон монголчуудтай хотуудад санал хураах байрыг аль болох олноор байгуулах, олон хотуудад байгуулах боломж бий юу?

Яах вэ, цахимын асуудал бол бас хардлагатай амаргүй гэдгийг бид мэдэж байгаа. Хэрвээ цахимын асуудал магадгүй удаашралтай байх юм бол бид санал хураах байрныхаа тоог аль болох олон хотуудад байгуулах ийм боломж бололцоо юу байгаа вэ гэдгийг нэгд асуумаар байна.

Хоёрт, одоо энэ цахимаар сонгуульд явуулж байгаа улс орнуудад халдлагад өртсөн тийм кэйс тохиолдол байна уу? Хэд хэдэн улсуудыг Та бүхэнд түрүүн танилцуулсан. Одоо дэлхий дээр энэ улс ингээд цахимаар яваад ингээд халдлага яагаад, гадаадад яадаг ийдэг ийм хэрэг дэлхийн түүхэнд ер нь гарсан юм уу, гараагүй юм уу?

Ж.Золжаргал: 5 дугаар микрофон. Тэгээд дараа нэмэлт шаардлагатай бол яая. 5-д залгачихсан шүү. Түрүүн хариу өгөөд байсан. 4 номерын микрофон.

П.Дэлгэрнаран: Тэгэхээр Д.Бум-Очир гишүүний асуултад хариулъя.

Жишээлбэл, дипломат төлөөлөгчийн газар байхгүй. Тэгсэн мөртөөсөө маш их олон монголчууд оршин суудаг хотууд байна. Америк байна, Солонгос байна, Швед байна. Тэгээд ийм олон монголчууд суудаг Европын улсууд байна. Герман байна гээд.

Тэгэхээр энэ улсууд дээр бид тэр монголчууд их олон оршин суудаг газруудад нь сонгуулийн хэсэг, санал хураах байрыг засаад явуулъя гэдэг

асуудлыг хөөцөлдөж үзсэн. Гадаад харилцааны яамтайгаа бид 2024 онд зөвлөлдсөн.

Энэ асуудлыг Женевийн конвенцоор зохицуулдаг юм билээ. Тэр конвенцын тодорхой заалтуудыг аваад үзэхээр бас яг бүрэн зөвшөөрөгдсөн тийм зүйл байдаггүй юм билээ. Тэгээд тухайн улсын нутаг дэвсгэр дээр бид өөрөөр хэлбэл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн конвенц, гэрээ.../минут дуусав/

Ж.Золжаргал: Нэмэлт цаг авах уу? Та. 1 минут 4 номер.

П.Дэлгэрнаран: Гэрээ, конвенцгүйгээр тухайн улсын нутаг дэвсгэрт дур мэдэн үйл ажиллагаа явуулах хэлбэрт шилжих вий гээд Гадаад харилцааны яам маань бас жаахан болгоомжилсон. Бид ч бас болгоомжилсон учраас үүнийг хийгээгүй.

Тухайн улсад нь хандаад тэр тухайн хотуудад нь, улсад нь хандаад энэ конвенцыг бариад яривал бас бүтэж болох талтай ажил юм билээ.

Ж.Золжаргал: П.Дэлгэрнаран даргын хариулт дээр нэмээд тэр жоохон техник талаас нь нөгөө баталгаажуулалт дээр хэлэх санаа байна уу? 5 номерын микрофон. 5 номерыг нээж өгнө.

Д.Даваа-Очир: Д.Бум-Очир гишүүн түрүүн хамгаалалтын системийн талаар ярьсан. Би энэ дээр бас нэмж зүйлүүдийг хэлье гэж бодож байгаа.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулиараа суурь бүртгэл хурууны хээн дээр явж байгаа. Тэгээд манай дата төвийнхөн ярьж байна. Тоон гарын үсэг тэндээс аваад сонгуульд оролцох боллоо гэхээр сонгуулийн нэрийн жагсаалт бол төрөлжсөн бүртгэлд явдаг. Тэгэхээрээ ажлын хэсэгтээ улсын бүртгэлийн газрын технологийн холбогдох улсууд цаашдаа байх ёстой. Тэр систем хамгаалалтыг хийдэг. Нэрийн жагсаалттай холбоотой нөгөө санал өгч байгаа үйл ажиллагаа бол манай Сонгуулийн хорооны төв сервер дээр ирж зохих журмын дагуу хамгаалагдаад явдаг. Одоо эдний бүтцийг нийлүүлээд таны хэлдгээр нөгөө халдлагатай холбоотой юмнуудыг иж бүрдлээр шийдчих юм бол одоо бидний дэд бүтэц одоохондоо салангид байгаа. Үүнийг нэгтгээд явчих юм бол тэр ажлын хэсэгтээ холбогдох улсуудаа оруулаад явчих юм бол үүнийг.../минут дуусав/

Ж.Золжаргал: Баярлалаа. Түрүүн П.Дэлгэрнаран даргын хариулт дунд энэ арга хэрэгслийг бүгдээрэнг нь л ашиглана шүү дээ гэсэн тиймэрхүү юм явчихсан. Тэгээд яг юуг хэрэглэхийг нь бид хараахан шийдээгүй байгаа шүү дээ.

Ер нь заавал цахим гэдэгтэй асуудал нь биш. Тийм ээ. Хамгийн гол нь гадаадад байгаа Монголын иргэн сонгууль өгч чаддаг байх ёстой. Тэр нь цахим

технологи байх уу, хосолсон байх уу, 4 арга байх уу, 5 арга байх уу, 2 байх уу гэдгийг одоо ингээд эхэлж байгаа. Та бас түрүүн яг цохож тэмдэглэлээ. Энэ ажил ингээд эхлэх ёстой.

Техникийн хувьд ямар боломж байна, эрх зүйн ямар асуудлууд байна гэдгийг Байнгын хорооны хүрээнд бид ямар ч байсан эхлээд ажлын хэсгээ гаргаад явна. Тэгээд ар араас нь ингээд шийдлийнхээ асуудлыг хийгээд эрх зүйн орчныхоо асуудлыг яриад явах байх.

М.Ганхүлэг гишүүний микрофоныг нээж өгнө үү.

М.Ганхүлэг: Цаг орой болсон ч гэсэн гадаадад байгаа иргэдийн асуудлаар, мөн дээрээс нь сонгуулийн үйл ажиллагааг илүү сайжруулах чиглэлээр ярилцаж байгаа ажлын хэсгийн гишүүд, танилцуулга хийсэн дарга нартаа баярлалаа.

Ерөнхий 2 гишүүн маань миний асуух гэж байсан асуултуудыг ер нь бүгдийг нь асуучихлаа. Тэгээд яах вэ тодруулаад тэгээд өөрийнхөө саналыг хэлье гэж бодож байна.

Энэ шинэ 30 жилийн тухай монголчууд бид бүхэн ярьж байна. Эрт орой ямар ч байсан энэ цахим шилжилт рүү орсны хамгийн төгс хэлбэр нь саналаа цахимаар өгөх энэ хэлбэр илрэх байх гэж ингэж харж байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр байгуулагдсан шинэ парламентад гадаад дотоодод сурсан нэлээн олон залуучуудын төлөөлөл орж ирсэн. Энэ нь ч бас арай сайхан үр дүнгээ өгөөд олон талаас асуудлыг нь харах энэ хэлбэр лүү явж байна.

Тэгэхээр бидний яг энэ ярьж байгаа асуудал өргөн агуулгаараа нэлээн чухал ажил эхэлж байна гэж хувь хүнийхээ хувьд бодож ач холбогдол өгч, танилцуулга мэдээллүүдийг харж байгаа юм.

Цаашдаа 126 гишүүний тодорхой санал өгөх гэдгээс гадна өөрсдийн гэсэн яг нэр бүхий төлөөлөлтэй болох тухай асуудал хүртэл зарим гишүүд санал гаргаад ярьж байгаа. Ганц нэгэн тойргийг гадаадад байгаа 200 гаруй мянган гишүүдэд өгөх тухай. Тэгээд тухайн гишүүн зөвхөн төлөөлөл байдлаар биш бүр сонгогдож суудаг байх тухай асуудлыг хүртэл ярьж байгаа.

Тэгэхээр энэ асуудал өргөн агуулгаараа нэлээн чухал болох болов уу.

Нөгөө талаасаа өргөн уудам газар нутаг, мөн саналаа өгч чадахгүй байгаа дотоодын сонгогч нарт ч гэсэндээ нэлээн дөхөмтэй байх болов уу гэсэн ийм бодлуудтай байгаа. Би яг тэр баталгаажуулалттай холбогдолтой асуудал дээр бид гар тооллогоос хар машин руу амжилттай шилжээд энэ ажлыг Сонгуулийн ерөнхий хороо нэлээн амжилттай сайн хийгээд. Гол нь давхар хяналтын тооллогыг хийгээд бүх сонгуулийн хэсгийн хороон дээр энэхүү

тооллого нь яг таг нийлж байгаа учраас монголчууд бид бүхэн хар машиныг хүлээн зөвшөөрөөд явж байна.

Үүнтэй адилхан яг энэ хяналт баталгаажуулалтын ажлыг яаж шийдэх вэ л гэдэг ийм асуултыг би ерөнхийдөө асуух гэж байсан. Тэгээд Та бүхэн ажлын хэсгийн хүрээнд нэлээн сайн дэлгэрүүлж ярилцах нь зөв байх.

Хоёр дахь нь, И-Монголиа дээр авч байгаа үйлчилгээнүүдийг бүгдийг нь бас авч чадахгүй байх тохиолдол байна. Заавал утасны дугаартай байхаас авхуулаад ингээд эрсдэлүүд бас тулгараад байх шиг байна.

Зарим зөвхөн мэдээллийн чанартайгаар авах байдаг юм уу, ийм мэдээллүүдийг мэйл хаяг, аппл ID-аараа нэвтрээд ч байдаг юм уу авах ийм дундын шатны хувилбаруудыг бас бий болгох боломжууд байх уу?

Ингээд бүр нарийн мэдээллийг бол заавал ч үгүй баталгаат дугаар юмнуудыг бас авах ийм шийдлүүд байгаа байх гэсэн ийм байна.

Тэгээд энэ тал чиглэлээр нэлээн өргөн хүрээнд ярилцах байх гэж бодож байна. Тийм.

Ж.Золжаргал: Гишүүний асуултад хэд дээр хариулах вэ? 2 дугаар микрофон нээж өгнө үү.

Б.Мягмарнаран: И-Монголтой холбоотой иргэн төрийн үйлчилгээ авахдаа хялбаршуулсан байдлаар нэвтрэх боломжтой юу гэдэг дээр нэмэлт тайлбар өгье.

Бид нарын хувьд одоогийн үзүүлж байгаа хувилбар хамгийн боломжтой энгийн хэлбэрээр гэдэг байдлаар энэ хувилбарыг гаргасан байгаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын зүгээс биднээс шаардаж байгаа зүйл бол одоо байгаа, Тагнуулын ерөнхий газраас зүгээс ч бас хэлж байгаа зүйл бол одоо байгаа зүйл бол хамгийн хялбар байна. Энэ чинь яг юу гэдэг юм, банкны эрхээр юм уу, бүртгэлтэй утасны дугаараар нэвтэрч ороод мэдээллээ харж байгаа чинь нэг төрлийн үйлчилгээ. Үүнээс цаашаа мэдээллээ өөрчлөх ч байдаг юм уу, хоёр болон түүнээс дээш шатлалтай үйлчилгээг авахдаа цахим гарын үсгээр зөвшөөрдөг хэлбэр лүү л ороох ээ гэдгээр бид нарыг шахаад байгаа. Өөрөөр хэлбэл түрүүний имэйл хаяг болон аппл ID ч юм уу тэрийг хэн нэгнийхтэй ижилхэн байдлаар үүсгэх боломжтой болохоор тэрийг зөвшөөрөхгүй гэсэн.

Тэгэхээр бид нарын хувьд одоо үзүүлж байгаа нь нэг шатлалтай болон иргэн өөрийн мэдээллээ үзэх боломжтой хамгийн доод хэлбэр дээрээ байгаа.

Ер нь цаашдаа цахим гарын үсгийг нэвтрүүлэх шаардлагатай л гэж үзэж байгаа.

Ж.Золжаргал: Болсон уу? Тийм ээ. Баярлалаа.

Би бас ганц нэг зүйл асууя. Энэ баталгаажуулалтын хувьд биометрикийг ашиглаад баталгаажуулахаар тэр нь бас өөрөө баталгаатай байж чадахгүй байна. Янз бүрийн видео дүрс, дуу хоолой, бичлэг энэ тэр ашиглаад нэвтэрдэг гээд.

Эстонийн жишээ дээр хэд хэдэн төрлийн нэвтрэлтийн системүүдийг ашиглаж байж нөгөө давхар давхар баталгаажуулаад тэгээд л явдаг л юм байна лээ л дээ. Тэгээд энэ тал дээр хослуулбал. Саяын хариулт дээр нэмээд хэлэхэд хослуулаад ашиглах иймэрхүү шийдлүүд Та бүхэн бодож байсан болов уу?

Хоёрдугаарт нь, мэдээж мэдээллийн аюулгүй байдал их чухал шаардлагууд шалгууруудынх нь нэг болж таарна.

Тэгэхээр тэр улсын интернэтийн системээр дамжуулаад ингээд манайхан цахимаар ороход мэдээллийн аюулгүй байдлыг нь гарч болзошгүй ямар эрсдэл, яг тэр эрсдэлд таарсан ямар шийдэл байж болох вэ?

Гурав дахь асуулт нь, цахимаар сонгууль өгөх юм бол санхүүжилт шаардлагатай төсөв хэд болох бол? Ямар нэгэн тийм хийсвэр ч юм уу, зүгээр ажлын шугамаар хийж байсан баримжаа тоо гаргаж байсан зүйл байгаа болов уу?

Тэгээд дөрөв дэх асуулт нь, баталгаат шуудангаар санал авдаг туршлага олон улсад их байдаг. Сая ПДэлгэрнаран даргын танилцуулга дээр гарсан. Тийм ээ.

Тэгэхээр энэ чинь техникийн нэг их айхтар өндөр хөгжил шаардагдахгүй. Тэгээд өдий болтол манайхан 200 гаруй монгол иргэн байхад яагаад үүнийг ер нь хэрэглээгүй юм бол? Та энэ олон жил ажиллаж байгаа хүн. Д.Бат-Эрдэнэ дарга ч байна. Тэгээд энэ баталгаат шууданг ер нь яагаад манайхан сонгууль авахад хэрэглэж байгаагүй юм бол? Үндсэн шалтгаан нь юу байдаг юм бол?

Иймэрхүү асуултууд байна. 3 номерын микрофон нээж өгнө.

М.Баттулга: ДАН системийн шинэчлэл дээр түрүүний танилцуулга дээр бас дурдагдсан. Бид энэ царай танилтыг ер нь ашиглая гээд.

Тэгэхээр ер нь сая Б.Мягмарнаран даргын хариултад дурдагдсан. Эцсийн дүндээ иргэний мэдээллийг Монгол Улсын иргэний М.Баттулгын мэдээллийг М.Баттулга л авахгүй бол өөр хүнд очихоор ингээд асуудал үүсээд байгаа

учраас баталгаажуулалтыг бол нэлээн өндөр түвшинд авч үзэх ёстой болчхоод байгаа юм.

Тэгэхээр бид саяын энэ царай танилт дээр олон улсын өмнө нэлээн кэйсүүд гараад зураг уншуулсан, хүний өмнөөс уншуулсан ч гэдэг юм уу ийм шийдлүүд нэлээн явсан. Сүүлийн үед царай танилтын хиймэл оюун ухаантай хосолж ажилладаг болсноор нэлээн өндөр хувьтай таних боломж бүрдэж байгаа.

Тэгэхээр бид түрүүний хэлсэн яг энэ танилтын систем дээрээ гурван түвшний эрхээ үүсгэе гэж байгаа.

Тэгэхээр зайнаас иргэн царайгаа таниулаад бүртгүүлж байгаа бол нэгдүгээр түвшинд буюу өөрийнхөө мэдээллийг харах түвшиндээ. Дараагийн түвшнийх нь бол тоон гарын үсгээр нэвтрэх юм бол илүү өөр түвшинд үйлчилгээ авах боломжтой. Яагаад гэхээр эцсийн дүндээ энэ маань шүүх дээр очихоор яг иргэнийг таньсан юу маань өнөөдрийн тоон гарын үсгийн тухай хуулираа тоон гарын үсэг л байгаа учраас бид илүү энэ тоон гарын үсэг рүүгээ шахаж явж байгаа.

Ж.Золжаргал: Тэр нөгөө биометрик чинь энэ Apple, Huawei, Google гээд эд нарын юунууд байгаа шүү дээ. Энэ технологиор дамжиж.

Тэгэхээр энэ талдаа аюулгүй байдлын ямар нэгэн зөрчил байна уу?

М.Баттулга: Смарт утасныхыг хэлж байна. Тийм ээ. Тийм. Смарт утасныхаар тэр анхны танилтыг бол хийхгүй. Бүртгүүлээд орсны дараа систем рүүгээ нэвтрэх танилтыг бид смарт утасны биометрик өгөгдлийг ашиглая гэж байгаа юм. Түүн дээр боломжтой гэж харж байгаа.

Ж.Золжаргал: Түрүүний 4 асуулттай холбоотой нэмэлт хариулт. 4 дүгээр микрофон нээж өгнө үү.

П.Дэлгэрнаран: Ж.Золжаргал даргын асуусан асуултад тэр шуудан хэрэглээгүй гэдэг асуудлыг.

Зүгээр шуудангийн хувьд бид одоо яг манайд байгаа энэ шуудангийн сүлжээ, шуудангийн баталгаажилт энэ маань одоо яг энэ сонгогчдын саналыг баталгаатай хүргэх энэ дэд бүтэц маань хөгжиж чадаж уу, үгүй юу гэдэг дээр дүгнэлт гаргаж зайлшгүй баталгаажуулах, итгэмжлэх шаардлагатай юм билээ.

Ж.Золжаргал: Уучлаарай. Нөгөө гадаадад байгаа монголчуудын хувьд учраас.

П.Дэлгэрнаран: Тийм. Гадаадад байгааг бас авч болно.

Тэгэхдээ манайхан шуудангийн хэлбэрийг анх эхэлж хууль тогтоомждоо оруулаагүй нь ер нь ихэвчлэн хардлагаас айсан, болгоомжилсон ийм юу байгаа.

Тэгэхдээ шуудан хамгийн баталгаатай шуудан. Жишээлбэл, Америкийн Нэгдсэн Улсын одоогийн сонгогчдын саналыг дамжуулж байгаа шуудангийн систем нь төрийн өмчийнх байгаа.

Тэгээд тэднийх энэ ажлыг явуулахдаа хамгийн найдвартай хийх газар нь төрийн өмчийн шуудан гэж үзэж зөвхөн төрийн өмчийнхөө шуудангаар дамжуулж байгаа.

Манайх нэг хэсэг манай шуудангийн систем маань бүр байхгүй ч болсон үе байгаа. Тэгээд энэ шуудангийнх маань энэ сүлжээ, баталгаат байдлаас болоод одоо хүртэл явж ирсэн. Тэгэхдээ шуудангийн хэлбэрийг ашиглах нь маш сайн байгаа юм. Энэ чинь бол бас нөгөө урьдчилсан санал хураалтын л нэг хэлбэр болчхоод байгаа юм.

Тэгэхээр энэ ирцэд сайн нөлөөлдөг. Шуудангийн хэлбэр маш үр дүнтэй хэлбэр гэж бид үзэж байгаа. Шуудангаар ирсэн саналыг баталгаажуулна, уншуулна, тоолно гэдэг бас нэлээн процесс ажил. Энэ дээр бол хүн хүч шаардана. Мөн үүний ил тод байдлыг хангах асуудал бас их гарч ирнэ гэж бодож байгаа.

Ж.Золжаргал: Хариулт авлаа. Баярлалаа.

Яах вэ, бид бас ингээд мэдээлэл цуглуулаад ажлын албаныхантайгаа ярилцсан л даа. Жишээ нь, тэр чинь давхар конверт ашигладаг юм байна лээ шүү дээ. Германд бол. Тэгээд л яг уутан дотроо нээгээд лацтай нээх боломжгүй зөвхөн нэг удаа л нээдэг ийм сонгуулийн нэргүй нэрийн сонгуулийн саналын хуудас нь явж байдаг. Гадна талд нь битүүмжлэлтэй баталгаатай конвертод хийчихсэн байдаг. Тэгээд хэд хоногийн турш сонгууль нь үргэлжилдэг иймэрхүү практик өнө удаан хэрэглэгдээд, эрсдэлээс сэргийлэх арга нь ч бас нэвтэрчихсэн ийм зүйлс байгаа.

Тэгэхээр ер нь цаг хугацаанаас болж л байна гэж харж байна л даа. Тийм ч учраас энэ Байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулах шийд гараад явж байна.

Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү.

Д.Бум-Очир гишүүний микрофоныг нээж өгье.

Д.Бум-Очир: Юуны өмнө орой болтол хүлээж хурлууд өнөөдөр нэлээн сунжирч байна. Та бүхэн тэвчээртэй энэ асуудлыг хэлэлцэхээр хүлээсэнд баярлалаа.

Энэ бол зөвхөн хилийн чанад дахь Монголчуудын санал өгөх боломж, нөөц бололцоог нэмэгдүүлэх тухай асуудал биш юм. Цаашлаад дэлхий нийт угаасаа цахим хөгжил рүү явж байна. Бид жил ирэх тусам сонгуулийнхаа ирцийг нэмэгдүүлэх шаардлага юу юугүй тулна.

Сонгогчид маань илүү их залуужиж байна. Энэ шинэ залуу үеийнхэн маань бол цахим орчинд илүү их ажилладаг, цахим орчинд илүү их цаг өнгөрөөдөг ийм эрин үе бидэнд тулаад ирчихсэн байгаа.

Тэгэхээр холын ирээдүйг харвал зөвхөн 220 юм уу, 280 ч гэж янз бүрийн тоо яригдаж байх шиг байна. Иргэдийн тухай асуудал биш ээ. Нөгөө талаар манай Монгол Улсын хувьд ч гэсэн нөхцөл байдал ирээдүйд харах юм бол бид нүүдлийн соёл иргэншлийн түүхтэй ийм ард түмэн. Малчин иргэд хэчнээн байгаа билээ. Хөдөө малтайгаа мал дээрээ байгаад саналаа өгч чаддаггүй иргэд хэд байгаа билээ гээд бодоод үзвэл яах вэ ер нь сонгуулийн санал өгөх арга технологийг улам олон болгох шаардлагатай байгаа.

Тэгээд түрүүн хэлсэн. Нэг нь цахим. Нөгөөдөх нь сая бол магадгүй шуудан байж болох юм. Цаашлаад сонгуулийн санал авах байрны тоог нэмэгдүүлэх гэх мэтчилэнгийн олон гарц гаргалгаануудыг бид судалж үзэж боломжтойг нь хэрэглээнд нэвтрүүлэх шаардлагатай байгаа. Энэ бол бид нарын сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх, энэ нийгэм, улс төрийнхөө асуудалд оролцох иргэдийнхээ оролцоог нэмэгдүүлэх ийм чухал ач холбогдолтой асуудал юм.

Мэдээж үүнийг дагаад хамгаалах, сэргийлэх гээд олон зүйл гарч ирнэ. Үүнийгээ бид тооцож, бодолцож судалж үзэхээс өөр аргагүй.

Нөгөө талдаа бид “Цахим үндэстэн” гээд бодлого дэвшүүлээд төлөвлөгөө гаргаад явж байгаа. Үнэхээр сонгуулийн саналыг цахимаар авдаг болно. Ялангуяа эхний ээлжид магадгүй туршилтын байдлаар хилийн чанадад байгаа монголчуудаа цахимаар саналыг нь өгүүлнэ гэж үзвэл миний ойлгож байгаагаар манай улсад хэрэгжиж байгаа үндэсний цахим системд тэд нарыг холбох гэх мэтчилний их том алхмууд, ажлууд хийгдэх, бүр нарийн ярих юм бол сонгуулиар санал өгдөггүй юм гэхэд манай улсад хэрэгжиж байгаа улсын үндэсний хэмжээний цахим системүүдэд том ахиц дэвшил гарах ийм олон давуу талтай гэдгийг бид бас харах юм.

Өөрөөр хэлбэл Та бүхэн сая хэллээ. Энд сая танилцуулга хийсэн олон системүүд хоорондоо нэгдээгүй байх жишээтэй. Энэ бүгдийг нэгтгэх энэ тэр гээд ерөнхийдөө заавал сонгууль ярьдаггүй юм гэхэд зүгээр цахим хөгжлөө харахад

бас нэг том алхам урагшлах ийм ач холбогдолтой үйл ажиллагаа байгаа гэдгийг бас онцлон дурдмаар байна.

Тэгээд энэ ажлыг дэмжиж санал бодлоо хуваалцаж мэдээллээр хангасан Та бүхэнд баярлалаа.

Ж.Золжаргал: Ингээд хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагын байр суурийг сонсъё гэж бодож байна.

Н.Номун-Эрдэнэ та ийшийгээ 1 дээр нэг дээр суучих уу. Солиод. 1 дүгээр микрофон нээж өгнө үү?

Н.Номун-Эрдэнэ: Та бүхний энэ оройн амгаланг айлтгая. Юуны өмнө Инновац, цахим бодлогын байнгын хороон дээр Хилийн чанад дахь Монгол иргэдийн сонгуулиа цахимаар өгөх гэдэг юм уу, бусад хэлбэрээр өгөх тухай асуудлыг хөндөж авч үзэж, бас холбогдох байгууллагууд нь оролцож байгаад бас их баяртай байна.

Тэгэхээр Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн хувьд өнгөрсөн 10 жилийн туршид хилийн чанадад байгаа иргэдийн санал өгөхтэй холбоотой асуудлаар байнга ярьж ирсэн. Тэр дундаа удаа дараагийн чуулга уулзалтуудад манай Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүн, удирдлага ирж мэдээлэл хийж, ер нь цаашдаа энэ сонгуулийг цахим хэлбэрээр зохион байгуулах боломжтой эсэх, мөн бусад хэлбэрээр зохион байгуулахад ямар дэвшил гаргаж болох вэ гэдэг талаар байнга ярьсаар ирсэн.

Ер нь хилийн чанадад өнөөдөр ажиллаж амьдарч байгаа монголчуудын тоо бол Гадаад харилцааны яамны мэдэгдэж байгаагаар 220 гаруй мянган иргэд байна. Эндээс сонгуульд санал өгөх эрхтэй тодорхой тооны иргэд байгаа.

Хамгийн гол яригдаж байгаа асуудал нь юу вэ гэхээр сонгуульд оролцох ирцийг нэмэгдүүлэхтэй холбоотой мэдээлэл сурталчилгааны ажлыг бид эрчимжүүлэх шаардлага байна гэж хардаг.

Хоёрт нь, хилийн чанадад байгаа иргэд дандаа бүгдээрээ нийслэлдээ ч гэдэг юм уу, дипломат төлөөлөгчийн газар байрладаг газруудад амьдарч чадахгүй байгаа. Энэ иргэдийн сонгуульд оролцох эрх эрхийг хангахад аль аль талаасаа маш сайн ярилцаж боломжтой хувилбарыг сонгох нь зүйтэй гэж харж байгаа.

Сая манай сонгуулийн болон бусад И-Монголиа Үндэсний дата төвийн улсуудын хамгийн гол ярьж байгаа зүйл юу вэ гэхээр цахимаар сонгууль авахад хамгаалалтын асуудал, аюулгүй байдлын асуудал гээд ярьж байна. Энэ бол бид нарын маш чухал анхаарах ёстой асуудал.

Төрийн эрх мэдлийг гаднын нөлөөтэй гэдэг юм уу, эсвэл аюулгүй байдлаа хангаж чадаагүйгээс болоод алдах тухай асуудал яригдаж байгаа учраас энэ бол бас чухал асуудал.

Нөгөө талаасаа Их Хурлын гишүүд манлайлал үзүүлж энэ дээр хамтарч ажиллаж байгаад таатай байна.

Та бүхэндээ дуулгахад Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлөөс санал болгосон хүсэлтийн дагуу гэдэг юм уу, мөн Их Хурлын гишүүдийн өөрсдийн санаачилгын дагуу “Хилийн чанад дахь иргэдийг дэмжих бүлэг” гэж албан ёсны ны бус бүлэг байгуулагдсан.

Энэ бүлгийн хэмжээнд бас яг энэ асуудал яригдаад Байнгын хорооноос ажлын хэсэг гараад ажиллахад манай Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлийн зүгээс өөрсдийн хийсэн судалгаа, мэдээллийг бас дамжуулж хамтарч ажиллахад.../минут дуусав/

Ж.Золжаргал: 1 номер дээр 1 минут нэмээд өгнө үү.

Н.Номун-Эрдэнэ: Тэгээд сүүлд нь хэлэхэд И-Монголиа үйлчилгээний тухай асуудал яригдаж байна.

Ний нуугүй хэлэхэд хилийн чанадад байгаа иргэд маань LIME гээд аппликэйшныг ашиглах боломж бүрдчихсэн. Гэхдээ яг үнэнийг хэлэхэд LIME аппликэйшнд итгэх итгэл байхгүй байгаа шүү. LIME гэж хаанахын ч компани юм. Нөгөө бид нарын уламжлалт сэтгэлгээгээр гар утасны сүлжээ гэдэг маань Мобиком, Юнител, Жи-Мобайл ч гэдэг юм уу яг нөгөө уламжлалт сэтгэлгээгээрээ хандаж байгаа. Тэнд итгэх итгэл нь явчихсан учраас LIME гэж хаанахын ч юу юм гэдэг байдлаар тэр өөрсдийн мэдээллээ тэдний байгууллагад өгөх итгэл сул байгаа.

Тийм учраас И-Монголиа академийн зүгээс гэдэг юм уу, холбогдох байгууллагууд нь энэ компанитайгаа хамтраад үнэхээр энэ компани хүлээн зөвшөөрөгдсөн, Монгол Улсын хэмжээнд тодорхой зөвшөөрлүүдээ аваад ажиллаж байгаа ийм компани гэдэг мэдээллээ маш сайн өгөхгүй бол итгэл нь.../минут дуусав/

Ж.Золжаргал: 1 номер дахиад 1 минут өгье.

Н.Номун-Эрдэнэ: И-Монголиа академитай бас Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл гэдэг юм уу, манай байгууллагын зүгээс хамтраад ер нь энэ LIME гэдэг юм бусад операторыг оруулж болох боломж байхгүй юм уу? Зөвхөн LIME гэдэг аппликэйшныг л ашиглах ёстой. Бусад нь боломжгүй юм шиг ийм ойлголт бас баймааргүй байна.

Тэгэхээр бусад Мобиком, Юнител, бусад гар утасны хүлээн зөвшөөрөгдсөн гэдэг юм уу, танигдсан компаниудад энэ боломжийг нь нээж өгөөд ингээд хамтарч ажиллавал болдоггүй юм уу. Тэгэх юм бол Монголчуудад маань илүү хэрэглээ нь нэмэгдэх болов уу гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

Ж.Золжаргал: Баярлалаа. Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гарсан тэр ажлын хэсэг маань бас яг энэ чиглэлээр удирдамж дээрээ оруулж ажиллах байх.

И-Монголиа үйлчилгээг яаж илүү хүртээмжтэй болгох вэ гээд. Тэгээд ганцхан LIME операторoос гадна Easy.mn ашиглаад. Easy.mn чинь гадаадад явж байгаа хүмүүс хэрэглээд л явдаг болчихлоо. Технологийн янз бүрийн шийдлүүд байдаг. Тэгээд тэр операторууд нь оролцсон уу. Түрүүний ярьсан тэр цахим гарын үсэг хэрэглэнэ үү. Ямар ч байсан бид шийдлийг олох ёстой.

Тэгээд ер нь бас тийм хүнд зүйл биш гэж урьдчилсан байдлаар хараад дүгнээд байгаа. Тэгээд нэн яаралтай бол үүнийг хэрэгжүүлэх шаардлагатай байх гэж бодож байна.

Ингээд гишүүд үг хэлж, асуудал хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Өнөөдрийн Байнгын хорооны хуралд оролцсон Та бүхэндээ баярлалаа.

Тэгээд эцэст нь хэлэхэд ер нь энэ XXI зууны өөрийнх нь өгөгдөл орчин нөхцөл нь өөр болчихсон. Монгол хүмүүс энэ нутагтаа төрж өссөн хүн ч бай дэлхийн хаана ч хамаагүй амьдарч ажиллаад явдаг л болчихсон. Ирж очдог л болчихсон.

Тэгээд тэр тусмаа энэ XXI зууны Монгол дэлхийн хэмжээнд тарж байрших нь эдийн засгийн утгаараа ч тэр, соёлын утгаараа ч тэр, улс үндэстний аюулгүй байдлын утгаараа ч тэр маш чухал ач холбогдолтой зүйл.

Хувь хүмүүс хоорондын харилцаанаас үүдээд гадаад харилцаанд хүртэл маш том эерэг нөлөөнүүд гарч ирдэг. Одоо энэ гадаадад байгаа монголчууд чинь 500 сая доллар хүртэл өнгөрсөн хугацаанд хамгийн их жилд оруулж ирж байсан тиймэрхүү дүн байсан шүү дээ. Нөгөө олж байгаа цалин хөлс, Монгол руугаа шилжүүлж байгаа мөнгөн дүн нь. Мэдээж бүгдээрээ бүртгэлгүй. Тэгээд тэрийг нь бодоод үзэхэд л уул уурхайн түүхий эдийн дараа гадаадад амьдарч байгаа монголчуудын оруулсан мөнгөн шилжүүлэг, тэрний дараа ноос, ноолуур гээд ингээд явж байгаа байхгүй юу.

Тэгэхээр эдийн засгийн утгаараа ч энэ чинь маш чухал. Тийм чухал дэлхийд Монголчуудын, энгийн үгээр хэлбэл бараг хөл гар болсон. Тийм ээ. Олон улсын харилцаандаа ч чухал, эдийн засгийн юугаар ч чухал ийм үр

нөлөөгөө өгч байгаа Монгол иргэдээ 200 гаруй 2 аймаг болчхоод байхад бид болтол сонгуульд нь оролцох нөхцөлийг хангалттай бүрдүүлж чаддаггүй. И-Монгол системдээ бас чөлөөтэй нэвтрэхэд нь төвөгтэй байдаг энэ зүйлсийг өөрчилье гээд.

Тэгээд өнөөдөр энэ талаар бас дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн Сонгуулийн ерөнхий хороо, И-Монгол академи, Үндэсний Дата төвийн удирдлагууд Та бүхэнд, хамт олонд баярлалаа.

Тэгээд өнөөдөр Инновац, цахим бодлогын байнгын хорооноос энэ асуудлаар ажлын хэсэг санал асуултаар байгуулсан.

Тэгээд ажлын хэсгийн даргаар Д.Бум-Очир дарга ажиллахаар болсон байгаа. Танд бас санаачилга гаргаад явж байгаад баярлалаа.

Тэгээд Улсын Их Хурал дээр түрүүнд энд бас танилцуулсан. Хилийн чанад дахь Монголчуудын эрх ашгийг хамгаалах гишүүдийн бүлгэм үүсээд байгуулагдаад ажиллаж байгаа. Тэр бүлгэмийн тэргүүн нь бол бас Д.Бум-Очир гишүүн ажиллаж байгаа.

Тэгээд энэ үүргийнхээ хүрээнд санаачилгыг ажлын хэсгийг бас ахлаад явах юм байгаа юм.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 38 минут үргэлжилж, 19 цаг 30 минутад өндөрлөв.

БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ **Ц.АЛТАН-ОД**